**2010**

# Орлогын Ажиглагч Индекс

**ИЛ ТОД БАЙДАЛ: ЗАСГИЙН ГАЗРУУД БА ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙ, УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ**

НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

# Орлогын Ажиглагч Индекс

Ил тод байдал: Засгийн газрууд ба газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэл

© Нээлттэй Нийгэм Форум, 2011
Монгол хэл дээрх зохиогчийн эрхийг ННФ эзэмшинэ.

Энэхүү судалгааг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах,
дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: http://www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

DDC
000000

ISBN 978-000000000000

# Өмнөх үг

Үүцээ нээж байгаа Монгол Улсын хувьд байгалийн баялгаа хүний хөгжил, сайн засаглал, тогтвортой ардчиллын баталгаа болгон хувиргах их аяны гараан эхлүүлээд байгаа билээ. Ард түмний мэдлийн байгалийн баялгийг гагцхүү ард түмний төлөө зөв бодлого гарган, түүнийгээ үр ашигтай хэрэгжүүлэн байж ашиглах шаардлага тулгарч байна. Бодлого нь ил тод, хэрэгжилт нь иргэдийн шууд оролцоотой, хяналтан дор нээлттэй явагдаж байж төр засаг иргэдийнхээ итгэлийг хүлээхийг өнөөгийн Монгол Улс дахь нөхцөл байдал, байгалийн баялагтай бусад олон орны ойрын жишээ харуулж байна. Ил тод, нээлттэй байдал нь байгалийн баялаг жинхэнэ эзэн ард түмэндээ үр шимээ өгөх, мөн төр засаг нь ард иргэдийн нэрийн өмнөөс баялгийг өндөр хариуцлагатайгаар удирдах үндсэн угтвар нөхцөл, баталгаа болж байна.

Тэгвэл баялгийг ашиглах бодлого, түүний хэрэгжилтийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх тодорхой үзүүлэлтүүдийг боловсруулж, түүнийгээ хянаж байх нь чухал ач холбогдолтой. Олон улсын түвшинд анх удаагаа байгалийн арвин их баялагтай 41 улс орныг хамруулсан Орлогын Ажиглагч Индексийг АНУ-д төвтэй төрийн бус Орлогын ажиглагч хүрээлэн, олон улсад үйл ажиллагаагаа явуулдаг Транспарэнси Интернэшнл байгууллагуудаас хамтран гаргасан нь Монгол Улсын хувьд онцгой ач холбогдолтой болсныг тэмдэглэн, үндсэн тайланг нь уншигч танд эх хэлнээ хөрвүүлэн хүргэж байгаадаа Нээлттэй Нийгэм Форумын хамт олон баяртай байна.

Уг индекс нь уул уурхай, газрын тосны бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүрсэн түвшнээ бодитойгоор үнэлэх, бодлого боловсруулагч болон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд суурь мэдээлэл болж өгнө гэж итгэж байна. Төр засаг нь бодлогоо зүгшрүүлэхэд, иргэний нийгэм мэдээлэлд тулгуурлан төр засгийн бодлогыг хянахад, хөрөнгө оруулагч, салбарын бизнес эрхлэгчид бүтээн байгуулалтынхаа үр шимийг ард түмэнд хүрч байгааг харах боломжоог энэ судалгаа бага боловч нээж өгч байгаад эргэлзэхгүй байна.



П. Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал

# Оршил

Орлогын ажиглагч институт ба Транспэрэнси Интернэйшнл нь 2007 оноос хойш Орлогын ил тод байдлыг хөхиүлэн дэмжих төсөл дээр хамтран ажиллаж байна. Бидний зорилго бол газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн үйлдвэрлэл эдийн засагт нь томоохон үүрэг гүйцэтгэдэг орнуудад орлогыг ил тод болгохын ач холбогдлыг Засгийн газар, хувийн хэвшлийн ба төрийн өмчийн компаниуд, мэргэжлийн хүмүүс, идэвхтнүүдэд таниулж, мэдлэг мэдээллийг нь дээшлүүлэх замаар сайн засаглалыг хөхиүлэн дэмжихэд оршдог.

Энэхүү төсөл нь улс орнууд байгалийн баялгийнхаа үр шимийг хүртэхийн зэрэгцээ олборлох үйлдвэрлэлийн сөрөг үр нөлөөг аль болох багасгахад туслах гэсэн иргэний нийгмийн байгууллагуудын олон талын хүчин чармайлтыг тусгаж байна. Эдгээр хүчин чармайлтын нэг нь Хүүхдийг ивээх сангаас 2005 онд гаргасан «Хоосон амнаас цааш» нэртэй тайлан юм. Цаашлаад, хөгжиж байгаа орнуудад олборлох үйлдвэрлэлийн ач холбогдлын талаарх мэдлэг дээшилсэн нь Транспэрэнси Интернэйшнл байгууллагаас 2008 онд Газрын тос, байгалийн хийн компаниудын орлогын ил тод байдлын тайлан гаргаж нийтлэхэд хүргэсэн юм.

*Орлогын Ажиглагч Индекс нь парламентын гишүүд, корпорациуд, иргэний нийгмийн байгууллагууд , хэвлэл мэдээллийнхэн болон иргэд Засгийн газраас газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн талаар илүү өндөр стандартыг хангасан тайлагналыг шаардахад зориулсан хэрэгсэл юм.*

Олон улсын иргэний нийгмийн зүгээс гаргасан ихээхэн хүчин чармайлтын ачаар олборлосон баялгийн удирдлага дахь ил тод, хариуцлагатай байдал сүүлийн арван жилд олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээний бодлогын тэргүүлэх асуудал болоод байна. Өнөөдөр байгалийн баялаг ихтэй орнуудын эдийн засгийн амжилтын шийдвэрлэх хүчин зүйл нь олборлох үйлдвэрлэлийн салбар дахь сайн засаглал болох нь харагдаж байна. Гэвч засгийн газруудад орлогын ил тод байдлын бодит багц стандарт үзүүлэлт байхгүй байгаа нь газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн орлогын хариуцлагатай, ил тод, үр нөлөөтэй удирдлагыг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтад саад тотгор учруулж байна.

Орлогын Ажиглагч Индекс нь энэхүү орон зайг нөхөж, компаниудын өмнө нь хийгдсэн ил тод байдлын үнэлгээнд нэмэлт болохоос гадна энэ чиглэлээр ажилладаг бодлого боловсруулагчид, идэвхтнүүд ашиглах чухал эх сурвалж болох юм. Түүнчлэн олборлох үйлдвэрлэлийн салбарт ил тод, хариуцлагатай байдлыг илүү өндөр жишигт хүргэх хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх болно.

Энэ индексийг компаниудын тайлантай хослуулснаар байгалийн баялаг ихтэй орнуудад ил тод байдлыг хэмжих, хариуцлагатай байдал, сайн засаглалыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн сайн шалгуур үзүүлэлтүүд бий болох хамтын, тогтвортой хүчин чармайлтын нэг хэсгийг бүрдүүлнэ.



Карин Лиссакерс
Орлогын ажиглагч институтын
Захирал



Др. Кобус де Суардт
Транспэрэнси Интернэйшнлийн
Нарийн бичгийн дарга нарын газрын
Удирдах захирал

# ОРЛОГЫН АЖИГЛАГЧ ИНДЕКС
## УЛС ОРНУУДЫН ЗЭРЭГЛЭЛ




**1. Орлогын иж бүрэн ил тод байдал**

**2. Орлогын хэсэгчилсэн ил тод байдал**

**3. Орлогын хязгаарлагдмал ил тод байдал**

Улс орнуудын оноог гаргахдаа Орлогын Ажиглагч Индексийн ил тод байдлын үзүүлэлтүүдийн дунджаар тооцов. Улс орнуудын зэрэглэлийг дундаж оноогоор нь жагсаав.

Энэ тухай дэлгэрэнгүй судлах, тайлангийн мэдээллийг татаж авахыг хүсвэл www.revenuewatch.org/rwindex хаягаар үзнэ үү.

# Хураангуй

*Энэхүү индекст дэлхийн хүн амын бараг тал хувийг хамарсан, мөн газрын тос, алт, зэс, алмаазын тэргүүлэх үйлдвэрлэгч, байгалийн баялаг ихтэй 41 улсыг үнэлсэн болно.*

Орлогын Ажиглагч Индекс нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл, түүний дотор байгалийн нөөц ашигласны төлөө Засгийн газарт төлж байгаа төлбөр, үйлдвэрлэлийн тоо баримт, гэрээний нөхцлүүдийн талаар Засгийн газраас нийтэд тайлагнаж байгаа мэдээллийг хэмжиж, харьцуулах гэсэн анхны оролдлого болж байна. Байгалийн баялаг ихтэй орнуудын болон дэлхий нийтийн эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн салбар чухал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Газрын тос болон түүнээс гаралтай бүтээгдэхүүн дэлхийн худалдааны 15 хувийг бүрдүүлдэг бөгөөд байгалийн баялагтай холбоотой тусгаар баялгийн сангуудын 2 их наяд орчим ам.долларын хөрөнгө дэлхийн санхүүгийн зах зээлийн гол тоглогчид байдаг. Аж үйлдвэржсэн орнууд эдгээр нөөц баялгаас ихээхэн хамааралтай байдаг бөгөөд хөгжиж байгаа орнуудын олборлох үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалт илт нэмэгдэж байна. 2000-2008 онд Африк тивийн ДНБ-ий 24 хувийг эрдэс баялгийн салбарын орлого эзэлж байсан бол ирэх 20 гаруй жилд тооцоолсон нүүрстөрөгчийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 90 орчим хувийг хөгжиж байгаа орнуудаас нийлүүлэх төлөвтэй байна. Дэлхийн нүүрстөрөгчийн нөөцийн ойролцоогоор 80 орчим хувь нь төрийн өмчит компаниудын хяналтад байна. Үүнд голлох үүрэгтэй орнуудын нөөц баялгийн менежментийн чанар дэлхийн эдийн засагт бүхэлд нь нөлөөлөх болжээ.

Энэхүү индекст дэлхийн хүн амын бараг тал хувийг хамарсан, мөн газрын тос, алт, зэс, алмаазын тэргүүлэх үйлдвэрлэгч, байгалийн баялаг ихтэй 41 улсыг үнэлсэн болно. Тэдний дотор Норвеги, АНУ зэрэг аж үйлдвэржсэн орнуудаас гадна байгалийн асар их баялагтай боловч дэлхийн хамгийн ядууд тооцогддог орнууд ч багтсан. Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн орлогоос хамааралтай улс орнууд баялгийн зохисгүй удирдлага, авлига хээл хахууль, эзэрхэг дарангуй ёс, гүнзгий зөрчил мөргөлдөөнд онцгой өртөмтгий байж болохыг улс төрийн эдийн засагчид цохон тэмдэглэсэн байдаг.

Байгалийн нөөцийн орлогыг ил тод болгох нь түүний зохисгүй ашиглалт, авлигатай тэмцэх, нөөц баялгийн ашиглалтын асуудлаар иргэд төрдөө үл итгэх байдлыг багасгахад онцгой чухал ач холбогдолтой байдаг. Байгалийн баялгийн орлогыг ил тод, хариуцлагатай удирдах нь газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг олборлогч орнуудын амжилттай хөгжил, тогтвортой байдлын үндэс суурь мөн.

## Судлагдаагүй чиглэлд зориулсан шинэ хэрэгсэл

Орлогын Ажиглагч Индекс нь орлогын ил тод байдлыг хэмжихийн тулд байгалийн баялгийн менежментийн долоон гол чиглэлээр зохих мэдээлэл байгаа эсэхийг үнэлдэг. Үүнд:

- **Нөөц баялагт хүрэх боломж:** гэрээ, тусгай зөвшөөрлийн нөхцөл болзол, дэг журмуудыг нарийвчлан харуулсан мэдээлэл, түүнчлэн мэдээллийн хүртээмжтэй холбоотой эрх зүй, зохицуулалтын механизмууд байгаа эсэх.
- **Орлого бүрдүүлэлт:** нөөц баялгийн үйлдвэрлэл, төлбөр, мөн түүнийг хүртэх боломж, давтамжийн талаар төр засгийн байгууллагуудаас гаргаж нийтэлсэн дэлгэрэнгүй мэдээлэл байгаа эсэх.

- **Институцийн орчин:** орлого бүрдүүлэлтийн менежментэд оролцогч үндсэн оролцогчдын баримтлах дэг журам, гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, түүнчлэн дотоод болон бусад хяналт шалгалт байгаа эсэх.
- **Төрийн өмчит компани:** төрийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалын бүтэцтэй холбоотой мэдээлэл, үйл ажиллагаагаа тайлагнах практиктай холбоотой дүрэм журмууд байгаа эсэх.
- **Байгалийн баялгийн сан:** Сангуудын үйл ажиллагаа, тайлагналын практикийг удирдан зохицуулах дүрэм журмууд бий эсэх.
- **Орон нутгийн шилжүүлэг:** Төв, нутгийн захиргааны байгууллага болон улс төрийн байгууллагуудын хооронд орлого хуваах ажиллагааг зохицуулах хуулиуд, орлого хуваасан тухай мэдээллийг илээр тайлагнасан байдал.
- **Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС):** гишүүн орнууд ОҮИТБС-ын шалгуур үзүүлэлт (ОҮИТБС-ын тайлан, төлбөр тооцооны аудит, тулган нэгтгэлт, төрийн өмчит компаниудын орлого, төлбөрийн тухай мэдээллийг нийтлэх гэх мэт)-үүдийг хангасан байдлын түвшин.

Олон нийтэд зориулсан мэдээлэл ямар байгаагаас хамаарч эдгээр үзүүлэлтүүдэд 0-100 хүртэл оноо өгсөн багарсан үр дүнгг нэгтгэж улс орон бүрийн Орлогын ил тод байдлын эцсийн оноог тооцож гаргасан болно. Индексийн эцсийн үр дүнгээр нь улс орнуудыг онооны дараалаар жагсааж үзвэл гурван бүлэгт хуваах болохоор байна:

- **Орлогын иж бүрэн ил тод байдал** (дундаж оноо 67-100): энэ бүлгийн улс орнууд олборлох үйлдвэрлэлийн орлогынхоо талаар үлэмж хэмжээний мэдээллийг иргэддээ өгдөг. Засгийн газрууд нь тайлагналын практик маш сайтай, олборлох салбарын чиглэл бүрээрээ задлан харуулсан, дэлгэрэнгүй тоон мэдээллээр хангах хандлагатай байдаг.
- **Орлогын хэсэгчилсэн ил тод байдал** (дундаж оноо 34-66): жагсаалтын дундах бүлэгт хамаарах орнууд иргэдээ олборлох үйлдвэрлэлийн орлогын талаарх мэдээллээр хангадаг боловч тус индексийн нэг буюу түүнээс дээш чиглэлд ил тод байдлын ноцтой дутагдалтай байдаг.
- **Орлогын хязгаарлагдмал ил тод байдал** (дундаж оноо 0-33): жагсаалтын доод хэсэгт орсон улс орнууд иргэдээ мэдээллээр хамгийн бага хангадаг төдийгүй уг индекст хамрагдсан бүхий л чиглэлд тайлагналын практик муутай байдаг.

Түүнчлэн, Эрх зүй, зохицуулалтын хүрээний үзүүлэлтүүд нь эдгээр оронд ажиллаж байгаа газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн салбарын институцийн орчны талаарх мэдээллийг өгдөг. Энэ хэсэг мэдээллийг ил нээлттэй, хүртээмжтэй болгох буюу эрх мэдлээ дур зоргоор ашиглахад хяналт тавихыг шаардсан хууль тогтоомж, зохицуулалтууд байгаа эсэхийг шалгадаг.

## Үр дүн: Орлогын ил тод байдлын харилцан адилгүй дүр зураг

1. Орлогын Ажиглагч Индексээс үзэхэд энэхүү тайланд хамрагдсан дийлэнх орнууд (41-ээс 29) байгалийн баялгийн салбарынхаа тухай олон нийтэд хязгаарлагдмал мэдээлл өгч байна. Ийнхүү ил тод байдал дутагдаж байгаа нь иргэд улсын өмч хөрөнгийн ашиглалтын талаар Засгийн газартайгаа хариуцлага тооцох чадварыг алдагдуулж байна.
2. Азербайжан, Бразил, Чили, Колумб, Эквадор, Казахстан, Мексик, Норвеги, Перу, Орос, Зүүн Тимор, Америкийн Нэгдсэн Улс зэрэг орнууд эрдэс баялаг, нүүрстөрөгчийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тэдгээрээс олж байгаа ашгийнхаа талаар харьцангүй их мэдээлэл өгч байна.

3. Алжир, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Экваторын Гвиней, Гана, Кувейт, Саудын Араб, Танзани, Туркменистан зэрэг улсуудад газрын тос, байгалийн хий, уул уурхайн орлогын тухай мэдээлэл хомс буюу маш бага мэдээлэл өгч байна.
4. Судалгаанд хамрагдсан бүх орнуудаас гэрээний ил тод байдлыг хангасан нь тун ховор бөгөөд зөвхөн Колумб, Либери, Перу, Зүүн Тимор, АНУ-ын Засгийн газрууд л гэрээнүүдээ (түрээсүүдээ) бүрэн нийтэлж байна. Эдгээр орнуудын жишээн дээр ч мэдээлэл олж авахад хэцүү байж магадгүй. Олонх Засгийн газар гэрээнүүдээ ил болгоогүй, тэр ч бүү хэл хууль тогтоох байгууллагадаа ч тайлагнаагүй байна.

## Цаашдын чиглэл

Энэхүү индекс нь төр засгаас ил тод байдлыг дээшлүүлэх талаар хойшлуулшгүй хүчин чармайлт гаргах шаардлагатай байгаа чиглэлүүдийн дэлгэрэнгүй дүр зургийг харуулж байна. Чухамдаа судалгаанд хамрагдсан бараг бүх улсад сайжруулах шаардлагатай бодит орон зай оршин байгааг эндээс бид олж мэдсэн юм.

Индексийн үр дүнгээс үзэхэд, мэдээллийн нууцлалыг хадгалах шаардлагатай гэсэн тайлбар үндэслэлгүй болох нь харагдаж байна. Ихэнх улсын нууцалж байгаа мэдээллийг олон орон илээр тайлагнаж байгааг уг индекс харуулж байна. Мэдээлэл бол хариуцлагатай байдлын урьдач нөхцөл бөгөөд аливаа нарийн түвэгтэй салбарыг үр дүнтэй удирдахад онцгой чухал хэрэгсэл юм. Ил тод байдал бага байх нь эрдэс баялаг, нүүрс устөрөгчийн нөөц ихтэй орнууд эдгээр баялгаа хөгжлийн төлөө ашиглах чадварт ноцтой саад учруулж болно.

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн орлогын менежментийг сайжруулах, нийтийн сайн сайхны төлөө нөөц баялгийн хариуцлагатай менежментийг хөхиүлэн дэмжихийн тулд орлогын ил тод байдлаа дээшлүүлэхийг Орлогын Ажиглагч Институт (RWI), Транспэрэнси Интернэйшнл байгууллагаас төр засаг, парламентын гишүүд, иргэний нийгэм, компаниудад хандан уриалж байна.

# ГАРЧИГ


| | | |
|---|---|---|
| **1.** | **Оршил** | 10 |
| 1.1 | Яагаад Орлогын Ажиглагч Индексийг гаргах болов? | 10 |
| **2.** | **Аргачлал** | 14 |
| 2.1 | Улс орны хамралт | 15 |
| 2.2 | Судалгааны үйл явц | 16 |
| 2.3 | Судалгааны гол чиглэл | 16 |
| 2.4 | Хөндлөнгийн хяналт | 17 |
| 2.5 | Оноо өгөлт ба үр дүнгийн зохион байгуулалт | 17 |
| 2.6 | Орлогын Ажиглагч Индекст юу хамрагддаггүй вэ? | 19 |
| 2.7 | Орлогын Ажиглагч Индексийн тухай судалгаагаар тогтоосон гол баримт бичгүүд | 20 |
| **3.** | **Ерөнхий үр дүн** | 22 |
| 3.1 | Орлогын иж бүрэн ил тод байдал | 22 |
| 3.2 | Орлогын хэсэгчилсэн ил тод байдал | 25 |
| 3.3 | Орлогын хязгаарлагдмал ил тод байдал | 25 |
| **4.** | **Ангилал бүрийн үр дүн** | 27 |
| 4.1 | Нөөц баялагт хүрэх боломж | 27 |
| 4.2 | Орлого бүрдүүлэлт27 | 28 |
| 4.3 | Институцийн орчин | 30 |
| 4.4 | Газрын тос, байгалийн хий, уул уурхайн төрийн өмчит компаниуд | 31 |
| 4.5 | Байгалийн баялгийн сан (ББС) | 32 |
| 4.6 | Орон нутгийн шилжүүлэг | 33 |
| 4.7 | ОҮИТБС | 33 |
| | **Орлогын Ажиглагч Индекс** | |
| **5.** | **Эрх зүй, зохицуулалтын хүрээ** | **38** |
| **6.** | **Бүс нутгийн үр дүн** | **42** |
| **7.** | **Дүгнэлт, санал зөвлөмжүүд** | **44** |
| Хавсралт 1: Орлогын Ажиглагч Индексийн асуултууд | | 49 |
| Хавсралт 2: Орлогын ажиглагч индексийн оноо | | 52 |
| Хавсралт 3: Хянах ажиллагааны явцад орсон өөрчлөлтийн тоо | | 64 |
| Нэр томъёоны тайлбар | | 65 |
| Лавлах материалууд | | 67 |
| Нэмэлт тэмдэглэлүүд | | 68 |

# 1 Оршил

Австрали, Канад, Швед, АНУ гэх мэт хуучны аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн амжилтыг өдөөхөд эрдэс болон нүүрс устөрөгчийн баялаг нь тусалсан байдаг. Энэ нь эрдэс баялгийн нөөц ихтэй хөгжил буурай орнуудад эдийн засгийн огцом өсөлтийг санхүүжүүлэх боломж олгодог. Саяхан болсон дэлхийн санхүүгийн хямралын дараа ч гэсэн газрын тосны үнэ өндөр хэвээр байж, алт мэтийн металлын үнэ түүхэн дээд амжилт тогтоосон билээ. Ийнхүү үнэ өссөн нь эдгээр бараа түүхий эдийг үйлдвэрлэгч орнуудын олборлох салбараас олох орлого, хөрөнгө оруулалтын хэмжээг асар их нэмэгдүүлээд байгаа бөгөөд эдгээр оронд дэлхийн хүн амын бараг тал хувь нь амьдарч байна[1].

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг үйлдвэрлэгч эдгээр олон орон олборлох салбараасаа ихээхэн баялаг бий болгож байгаагаа эс тооцвол дэлхийн хамгийн ядуу улсын тоонд орж байна. Тухайлбал, Сахар орчмын Африкийн бүс нутагт газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч арван орон 2007-2030 онд газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөр, татвараас нийт 4 их наяд орчим ам.долларын орлого олох төлөвтэй байна. Эдгээр орлогын дийлэнх хувийг Ангол, Нигери улсууд хүртэх юм[2]. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Судан зэрэг газрын тос, байгалийн хий үйлдвэрлэгч орнууд ч бас улс төрийн хувьд хамгийн тогтворгүйд тооцогддог. Хэдийгээр олборлох нөөц баялгийн ирээдүй сайн байсан ч их хэмжээний нефть, ашигт малтмалын нөөц нь эдийн засгийн маш муу хөгжил, дарангуйллын дэглэм тогтохихээхэн магадлал, түүнчлэн зарим тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд хүргэхтэй ч холбогдох нь нь нийтлэг байдаг[3].

Олборлох үйлдвэрлэлийн салбарт засаглалын чанар онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр оронд бараг бүгдэд нь нийтлэг байдаг зүйл бол хөрсөн доорх байгалийн баялаг нь төрийн мэдлийн улсын өмч гэсэн Үндсэн хуулийн хэм хэмжээ юм. Иймээс газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн олборлолтын орлогыг зарчмын хувьд төр ард түмнийхээ нэрийн өмнөөс итгэлцлээр удирддаг. Улс, нийтийн өмчийн нөөц баялгийг улс орныхоо эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх, урт хугацааны хөгжлийг хангахад ашиглах ёстой гэж үзэх үндэслэлтэй. Олон улсын валютын сангийн мэдээгээр, 2000-2007 онд байгалийн баялаг ихтэй орнуудын бий болгосон төсвийн нийт орлогын дунджаар 40 хувийг нүүрс устөрөгч, эрдэс баялгийн орлого ээлж байжээ. Гэвч иргэд нь энэ салбарын талаар маш бага мэдээлэлтэй байдаг улс орон хэтэрхий олон байна. Мэдээлэл авах эрх байхгүй бол иргэд, олон нийт төрөөс олборлох салбарыг удирдаж буй шийдвэрүүд, олборлолтын нөхцлүүд, эрдэс баялгийн олборлолт, борлуулалтаас орж буй мөнгөний ашиглалтад нөлөө үзүүлэх нь маш хязгаарлагдмал байх болно.

### 1.1 Яагаад Орлогын Ажиглагч Индексийг гаргах болов?

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгаас орлогынхоо дийлэнх хэсгийг дагнан бүрдүүлдэг улс орнуудад орлогын ил тод байдал онцгой чухал ач холбогдолтой байдаг. Энэ орлого нь ихээхэн өөрчлөлттэй, тогтворгүй байдгийг 2008-2009 онд болсон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хямрал харуулсан билээ. Олборлох үйл

ажиллагаанаас Засгийн газрын бүрдүүлж буй орлого нарийн түвэгтэй томъёололтой байх, хүртэх ашгийн хэмжээ их байх нь улс орнуудыг хөрөнгө шамшигдуулах явдал болон авлигад онцгой өртөмтгий болгодог. Төр засгийн байгалийн баялгийн ашиглалтад үл итгэх, эсхүл нийгэм дэх баялгийн дахин хуваарилалтад сэтгэл дундуур байх нь БНКАУ болон Нигерийн сав газрын жишээ шиг гүнзгий зөрчил, мөргөлдөөнд хүргэж болно. Энэ нь дан ганц үндэсний хэмжээнд биш, бүс нутаг, орон нутгийн түвшинд ч үүсч болох бөгөөд дахин хуваарилалт хийх үед хэр их орлого олохоо гол төлөв мэдээгүй байдаг. Иймээс тэд олж байгаа орлогын тухай мэдээллээ нутгийн иргэдтэй тэр бүр хуваалцдаггүй. Эдгээр сорилтуудыг шийдвэрлэхэд ил тод байдал зайлшгүй шаардлагатай. Олборлох салбарын тухай иж бүрэн мэдээллээр тогтмол хангах нь тэдгээр нөөц баялгийг яаж хамгийн сайн удирдаж ашиглах талаар мэтгэлцээн өрнүүлэх боломжийг төр засгийн газрууд, хууль тогтоогчид, жирийн иргэдэд олгодог. Орлогын ил тод байдал нь аливаа салбар дахь олон нийтийн хяналтыг дэмжиж өгдөг бөгөөд эс тэгвэл хаалттай хаалганы цаана хээл хахууль, зохисгүй удирдлага цэцэглэх болно. Энэ бол аливаа улс институцийн хувьд хэр «хөгжингүй» эсэхээс үл хамаарах чухал асуудал болохыг АНУ-ын олборлох үйлдвэрлэлийн салбарт гарсан дуулиант явдлууд харуулдаг[4]. Эцэст нь, орлогын ил тод байдал нь нөөц баялгийг иргэдийнхээ ашиг сонирхолд хамгийн сайн нийцүүлэн ашиглахыг зорьж байгаа засгийн газарт итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлж өгдөг.

*Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэдийчинээ сайн хангана, засаглалын үнэлгээ, эдийн засгийн өсөлт нь тэдийчинээ өндөр байдаг байна.*

Энэхүү индексийн цаад санаа бол байгалийн баялгийн орлогыг ил тод, хариуцлагатайгаар удирдах нь газрын тос, байгалийн хий, эрдэс баялаг үйлдвэрлэгч орнуудын хөгжил, тогтвортой байдлын салшгүй хэсэг байдагт оршино. Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд олон нийтийн мэдээлэл авах эрхийг хэдийчинээ сайн хангана, засаглалын үнэлгээ, эдийн засгийн өсөлт нь тэдийчинээ өндөр байдаг байна[5]. Түүнчлэн, улс орон ил тод байх тусам зээлжих зэрэглэл өндөртэй, төсвийн сахилга бат сайтай, авлига багатай байдгийг судалгаа харуулж байна[6]. Цаашилбал, ил тод байдал багатай орнууд ил тод байдал сайтай орнуудыг бодвол нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нь бага, капиталын зардал өндөртэй байдаг байна[7].

Өнгөрсөн арван жилд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын асуудал анхаарал татаж эхэлсэн нь Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС), Төлснөө нийтэл (ТН) дэлхий нийтийн иргэний нийгмийн хөдөлгөөн хүрээгээ эрс тэлж байгаагаар харагдаж байна. Нөөц баялгийн орлогын ил тод байдлын тухай ОУВС-гийн удирдамж Байгалийн нөөцийн тунхаглал, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн Банк, Африкийн эвлэл зэрэг байгууллагуудын шинэ хөтөлбөрүүд бий болсон нь байгалийн баялаг ихтэй орнуудад олборлох салбарын засаглалаа сайжруулахад нь туслах сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна.

Гэвч, орлогын ил тод байдлын тухай тодорхойлолт нь компаниудаас төлж, засгийн газруудын хүлээн авч байгаа төлбөрийн тухай тоо баримтыг харьцангуй явцуу хүрээнд ил болгохоос хараахан хэтрэхгүй байна. Ийм төрлийн тайлагналт маш чухал боловч байгалийн нөөц баялгийг илүү өргөн хүрээтэй хөгжлийн төлөө ашиглах, түүнд хяналт тавих, сайжруулахад хангалтгүй юм.Иймээс Орлогын Ажиглагч Индекст орлогын ил тод байдлын тодорхойлолтын хүрээг тэлж, олборлох салбарын бусад холбогдох чиглэлүүдийг багтааж байгаа юм. Үүнд гэрээлэх ба тусгай зөвшөөрөл олгох журмууд, хууль эрх зүйн хүрээ, байгалийн баялгийн сангууд (ББС)-ын ашиглалт, газрын тос,

байгалийн хий, уул уурхайн төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа, орон нутгийн засгийн газарт олгох орлогын хуваарилалт зэрэг орно.

Орлогын Ажиглагч Индекс нь энэхүү арга замыг газрын тос, байгалийн хий, ашигт малтмал үйлдвэрлэгч орнуудын янз бүрийн бүлгийн хүрээнд орлогын ил тод байдлыг хэмжиж харьцуулахад ашигладаг. Тус индексийн зорилго бол олборлох үйлдвэрлэл (салбар)-ийн ил тод байдал гэж юу болох талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх замаар сайн засаглалын асуудлыг хэлэлцэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. Энэ нь аль нэг улс орны байдлыг хамгийн сайн туршлага төдийгүй адил төстэй бусад орнуудтай жишиж үнэлэх замаар харьцуулсан судалгааны хүрээг бий болгодог. Индекс нь улс орныхоо байдалд шүүмжлэлтэй хандаж, олборлох салбарын ил тод, хариуцлагатай байдлын өндөр хэм хэмжээ шаардахад ашиглаж болох үнэн зөв, бодитой тоо баримтаар иргэний нийгэм, парламентын гишүүдийг хангаж байдаг. Энэ бол газрын тос, байгалийн хий, ашигт малтмал үйлдвэрлэгч орнууд олборлох үйлдвэрлэлийнхээ тухай мэдээллийг олон нийтэд тайлагнах, мэдээллээр хангах тал дээр хэр сайн ажиллаж байгааг харьцуулан үнэлэх анхны хүчин чармайлт юм[8].

Уг тайлангийн мэдээлэл, түүний дотор улс орны онцлог баримт бичиг, мэдээллийг авахыг хүсвэл www.revenuewatch.org/rwindex хаягаар үзнэ үү.

## СТАТИСТИК ТОО БАРИМТ



Индекст хамрагдсан орнууд дэлхийн хүн амын бараг 50 хувийг бүрдүүлдэг

**41**

---

Индексийн хамгийн өндөр оноо: **Бразил Улс**

**97**

---

Индексийн хамгийн бага оноо: **Туркменстан Улс**

**9.7**

---

Газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүний дэлхийн худалдааны хувь, хэмжээ

**15%**

# 2 Аргачлал

Орлогын Ажиглагч Институт өгөгдөл цуглуулах зорилгоор аливаа засгийн газрын олборлох үйлдвэрлэлийн менежментийн тухай мэдээллийг олж тогтоон орлогын ил тод байдлыг тодорхойлоход чиглэсэн дэлгэрэнгүй асуулга боловсруулсан. Энэхүү асуулга нь ОҮИТБС, «Төлснөө нийтэл» кампанит ажил, Орлогын ил тод байдлын тухай ОУВС-гийн удирдамжаас дэвшүүлсэн стандартад тулгуурласан болно.

Уг асуулгаар газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын талаар засгийн газруудын нийтэлж байгаа мэдээлэлд өргөн хүрээтэй үнэлэлт өгсөн юм. Нэгдүгээрт, олборлолтын нөөц баялгийг хянаж удирдаж байдаг төрийн байгууллагуудын нийтэлдэг гол баримт бичгүүдийг асуулгаар тогтоодог. Эдгээр баримт бичиг нь тайлагналын практикуудын талаар мэдээлэл өгөхөөс гадна янз бүрийн улс орнуудыг харьцуулах шууд стандартаар хангадаг. Хоёрдугаарт, уг асуулга нь олон нийтэд хүртээмжтэй байгаа мэдээлэл болон ил тод байдлын тухай олон улсын заавар удирдамжууд, мэргэжилтнүүд, олон улсын кампанит ажлуудаар онцолсон цуврал асуудлаарх институцийн практикийг олж тогтоодог.

## Орлогын Ажиглагч Индексийн долоон ангилал

Тус индекс нь байгалийн нөөцийн удирдлагын гол асуудлыг төлөөлөх долоон ангиллаар цуглуулсан мэдээлэл дээр тулгуурлаж гардаг.

- **Нөөц баялагт хүрэх боломж:** гэрээ, тусгай зөвшөөрлийн нөхцөл болзол, дэг журмуудыг нарийвчлан харуулсан мэдээлэл, түүнчлэн мэдээллийн хүртээмжтэй холбоотой эрх зүй, зохицуулалтын механизмууд байгаа эсэх.
- **Орлого бүрдүүлэлт:** нөөц баялгийн үйлдвэрлэл, төлбөрүүд, мөн түүнийг хүртэх боломж, давтамжийн талаар төр засгийн байгууллагуудаас гаргаж нийтэлсэн дэлгэрэнгүй мэдээлэл байгаа эсэх.
- **Институцийн орчин:** орлого бүрдүүлэлтийн менежментэд оролцогч үндсэн оролцогчдын баримтлах дэг журам, гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, түүнчлэн дотоод болон бусад хяналт шалгалт байгаа эсэх.
- **Төрийн өмчийн компаниуд (ТӨК–иуд):** төрийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалын бүтэцтэй холбоотой мэдээлэл, үйл ажиллагаатай нь холбоотой тайлагналын практикууд байгаа эсэх.
- **Байгалийн баялгийн сангууд:** Сангуудын үйл ажиллагааг зохицуулах дүрэм журам, ажиллагаатай нь холбоотой мэдээлэл байгаа эсэх.
- **Орон нутгийн шилжүүлэг:** Төв, нутгийн захиргааны байгууллага болон улс төрийн байгууллагуудын хооронд нөөц баялгийн орлого хуваах ажиллагааг зохицуулж, энэ талын тайлагналын практикийг үнэлдэг хуулиуд.
- **Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОҮИТБС):** гишүүн орнуудын ОҮИТБС-ын шалгуур үзүүлэлт (ОҮИТБС-ын тайлан, төлбөр тооцооны хараат бус аудит, тулган нэгтгэлт, төрийн өмчит компаниудын орлого, төлбөрийн тухай мэдээллийг нийтлэх гэх мэт) - үүдийг хангаж байгаа хүрээг шалгана.

Тус асуулга нь ил тод байдлын асуудлуудыг эрх зүй, зохицуулалтын хүрээнээс ялгаж тодорхойлсон. Ил тод байдлын бүрэлдэхүүн хэсэг нь засгийн газраас долоон ангилал тус

бүрт холбогдох мэдээллийг нийтэлж байгаа эсэх, хэрэв нийтэлж байгаа бол хэр бүрэн дүүрэн, аль хэр давтамжтай гаргаж байгааг илэрхийлдэг. Харин эрх зүй, зохицуулалтын хэсэг нь олборлох үйлдвэрлэлийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох хууль тогтоомж, зохицуулалт, институцүүдэд хамаарах бөгөөд холбогдох чиглэлээрх шударга ёсны баталгааг хангаж өгдөг.

Асуулгын загварт тулгуурлан Орлогын Ажиглагч Индексийг ил тод байдалтай холбоотой асуултуудын энгийн дундаж байдлаар зохиосон болно[9]. Асуулт бүрийн оноог өгөхдөө уг асуулганд дурдсан мэдээллийг ямар нэг баримт бичиг, тогтмол хэвлэл, эсхүл онлайн мэдээллийн сан хэлбэрээр өгч байгаа эсэхэд тулгуурласан. Зөвхөн энэ төрлийн асуултыг ашигласнаар уг мэдээлэл тогтмол тайлан, баримт бичгийн хэлбэрт байгаа эсэхийг харьцуулах боломж олгох бөгөөд энэ нь улс орнуудын хэмжээгээр стандарт тогтоох энгийн арга юм.

Эрх зүй, зохицуулалтын хүрээний хэсгийн хувьд бид ОУВС-гийн удирдамж, Байгалийн баялгийн тунхаг зэрэгт заасан стандартуудыг авч хэрэглэн иж бүрэн тайлагналыг хөнгөвчлөх, мэдээлэл авах илүү их боломжоор хангах, эрх мэдлээ дур зоргоор ашиглахад хяналт тавих практикуудыг сонгосон[10]. Байгалийн баялаг ихтэй орнуудад тулгардаг хүндрэл бэрхшээлийг дан ганц ил тод байдлаар шийдвэрлэхгүй гэж үзсэний үндсэн дээр эдгээр асуултуудыг оруулсан болно. Гэвч шинэ стандарт, тэргүүн туршлагууд бий болж, хувьсан өөрчлөгдсөөр байна. Зарим тохиолдолд бодлогын зөвлөмжүүд нь зөвлөж зааварласан шинжтэй байж болно[11]. Түүнчлэн индексийн оноо нь дан ганц ил тод байдлын асуултуудад тулгуурладаг.

Эрх зүй, зохицуулалтын хүрээтэй холбоотой асуултууд нь тодорхой дүрэм журам, байгууллагын онцлог байгаа эсэхийг шалгадаг боловч тэдгээр нь практик дээр яаж ажиллаж байгааг нь үнэлдэггүй. Уг асуултууд нь иргэд, парламентчдын зүгээс дотоодын институцүүдийг үнэлж, үйл ажиллагааг нь сайжруулахад туслах зорилготой юм. Тайлангийн тусдаа нэг хэсэгт судлаачдын цуглуулсан мэдээллийг ашиглан эрх зүй, зохицуулалтын  хүрээний онцлогт товч задлан шинжилгээ хийж байна. Энэхүү индекс нь эрх зүй, зохицуулалтын хүрээнд оноо өгөхгүй бөгөөд эдгээр асуултаар цуглуулсан мэдээлэл нь тайланд хамрагдсан улс орнуудын нөхцөл байдлыг харуулахад хэрэгтэй байдаг.

*Судлаачид 2009 оны 11 дүгээр сараас 2010 оны 4 дүгээр сар хүртэл мэдээлэл цуглуулсан.*

## 2.1 Улс орны хамралт

Улс орнуудын сонголтыг хийхдээ ОУВС-гаас газрын тос, байгалийн хий, эрдэс баялгаас хамааралтай эдийн засагтай гэж тодорхойлсон 55 орноос эхэлсэн. Дээр нь бид ОҮИТБС-д нэгдсэн улс орнуудыг авч үзсэн болно. Энэхүү төсөл эхлэх үед уг санаачилгад 30 орон нэгдээд байсан бөгөөд тэдний зургаагаас бусад нь ОУВС-гийн тодорхойлолтод багтсан байв. Эцэст нь бид дээрх хоёр бүлэглэлийн аль алинд нь ороогүй боловч ашигт малтмалын бүтээгдэхүүн, түүхий эд үйлдвэрлэлээр тэргүүлэгч 10 орны тоонд ордог нүүрс устөрөгч, ашигт малтмалын таван томоохон үйлдвэрлэгчийг нэгтгэсэн юм (Австрали, Бразил, Канад, Хятад, АНУ). Энэ гурван ангиллын орнууд нийлээд боломжит 66 орны жагсаалтыг бүрдүүлсэн билээ.

Газар зүйн хувьд тэнцвэртэй сонголт хийхийн тулд бид зургаан бүс нутгийг тогтоосон:(1) Африк,  (2) Ази, Номхон далай, (3) Төв Ази, Орос, (4) Латин Америк, (5) Ойрхи Дорнод

ба Хойд Америк (ОДХА), (6) Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) гишүүн орнууд. Орлогын Ажиглагч Индексийг анхлан хэрэгжүүлэхэд зориулж бид эдгээр боломжит 66 улсаас 41 -ийг түүвэрлэн сонгож авсан юм. Хэдийгээр санамсаргүй бус сонголт байсан ч гэсэн бидний шинжилж байгаа улс орнууд харьцуулан үзэх боломжтой бүс нутгийн хувьд тэнцвэртэй төлөөлөл болсон. Энэ тайлангийн хувьд холбооны бүтэцтэй орнуудыг (Канад, Австрали гэх мэт) хасч оруулсан нь байгалийн баялгийн удирдлага, татвар ногдуулалт хариуцсан эрх бүхий байгууллагууд нь янз бүрийн онцлогтой байдгаас тэднийг харьцуулан судлах, нэгдсэн оноо өгөхөд бэрхшээлтэй байдагтай холбоотой.

## 2.2 Судалгааны үйл явц

Улс орон бүрт бие даасан зөвлөх ажиллаж 2009 оны 11 дүгээр сараас 2010 оны 4 дүгээр сар хүртэл уг асуулгыг бөглөх мэдээллээ цуглуулсан. Судалгаагаар 2006 оны 1 дүгээр сараас 2009 оны 12 дугаар сар хүртэл олон нийтийн хүртээл болгосон мэдээллүүдийг олж тогтооход гол анхаарлаа төвлөрүүлсэн болно. Энэ хугацаанд нийтлэгдсэн боловч 2006 оноос өмнөх мэдээллийг агуулсан тайлангуудыг түүхэн тоо баримтад тооцсон. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч хэд хэдэн орон 2010 онд тайлангаа шинээр гаргасан бөгөөд эдгээр тайланд нийтлэгдсэн шинэ мэдээллүүд уг индексийн дараагийн тайланд орж тухайн улсын оноог дээшлүүлэх нь дамжиггүй.

Судлаач бүр тодорхой нэг бүс нутгийн орнуудыг хариуцаж ажилласан бөгөөд тэдгээрийн талаар зохих мэдлэгтэй (түүний дотор тухайн орны хэл), өмнө нь ажиллаж байсан туршлагатай хүмүүс байв. Судлаачид улс орон бүрээр нарийвчилсан асуулга бөглөж, хариултуудаа нотлох баримтаар  хангаж байв. Судалгаа нь бидний тодорхойлсноор ямар ч иргэн,  эсхүл нийт иргэд интернетийн албан ёсны хуудаснаас, эсхүл тухайн баримт бичгийг («Гол баримт бичгүүд» гэсэн хэсгийг үзнэ үү.) гаргасан төрийн байгууллагад хүсэлт тавих замаар олж авах боломжтой нээлттэй мэдээлэлд тулгуурласан. Хэрэв нэг буюу түүнээс дээш гол баримт бичгийг зөвхөн олон нийтэд нээлттэй бус арга замаар олж авах боломжтой бол түүнийг асуулгын оноонд тооцоогүй. Түүнчлэн, судлаачид олж авсан мэдээллээ баталгаажуулах, мэдээллийн эх сурвалжаа өргөтгөх, технологийн, эсхүл орчуулгын шинжтэй алдааг зөөлрүүлэхийн тулд орон нутгийн мэргэжилтнүүд, иргэний нийгмийн идэвхтнүүд, төрийн албан тушаалтнуудтай аль болохоор уулзаж байв.

Тус индексийн тоо баримтуудын үндсэн эх сурвалж нь төрийн байгууллагуудаас интернетэд  (вэбсайт дээр) байрлуулсан мэдээлэл байдгийг дурдах нь зүйтэй. Учир нь энэ индексийн зорилго бол төр засгийн газрууд хэр их мэдээллийг олон нийтэд хялбар хүртээмжтэй сувгуудаар өгч байгааг сорих явдал юм. Судалгаанд хамрагдсан бүх улсын засгийн газар албан ёсны вэбсайттай, түүндээ холбогдох мэдээллийг тогтмол нийтэлдэг байна. Бидний аргачлалыг Ангол, Эквадор, Габон, Мексик, Норвеги, Перу, Өмнөд Африк зэрэг орнуудад урьдчилан турших үзэхэд холбогдох мэдээллийн нилээдгүй хувийг онлайн эх сурвалжаас авч, тайлагнаж мэдээлэх түгээмэл үүрэгтэй байгууллагуудыг олж тогтоосон.

## 2.3 Судалгааны гол чиглэл

Орлогын Ажиглагч Индекст газрын тос, байгалийн хий үйлдвэрлэдэг 30, ашигт малтмал олборлодог 11 орон багтсан байгаа. Ашигт малтмал олборлогчдын хувьд тухайн салбарыг бүхэлд нь хамарсан мэдээлэл олж авахыг судлаачид эрмэлзсэн. Гэхдээ газрын

тос, байгалийн хийн хувьд харьцангуй стандартчилагдсан байдаг бол уул уурхай нь үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнэ өртгийг тооцоолоход өөр өөр хэмжүүр ашигладаг олон тооны эрдэс баялаг үйлдвэрлэдэг нарийн түвэгтэй салбар юм.

Нүүрс устөрөгчийн нөөцөөр баян зарим орнууд ч бас эрдэс баялгийн чухал үйлдвэрлэгч байдаг нь шинжилгээг улам ярвигтай болгодог. Судалгаа нь олон янзын улс орнуудын хооронд харьцуулалт хийхийн тулд ОУВС-гийн тодорхойлсноор Засгийн газарт нь хамгийн их орлого оруулдаг нөөц баялгийг голлон анхаарсан болно. Ингэж шийдсэн нь нь манай судалгааны үр дүнд улс орон бүрийн олборлох салбарыг бүхлээр нь авч үзээгүй гэсэн үг. Гэсэн хэдий ч, судалгаанд хамрагдсан дийлэнх орны улсын төсвийн орлогын ихэнх хэсгийг бүрдүүлдэг нөөц баялгийн хувьд бидний олж мэдсэн зүйлс, хийсэн дүгнэлтүүд хүчинтэй[12].

## 2.4 Хөндлөнгийн хяналт

Асуулга бүрийн хариултыг нягтлан шалгах үүднээс судалгааны үр дүнг өөр хүмүүст өгч мөн улс бүрийн асуулгыг дор хаяж нэг мэргэжилтнээр давхар хянуулсан болно[13]. Ихэнх хөндлөнгийн хянагчид орлогын ил тод байдлын хөдөлгөөнийг сайн мэддэг, тухайн улс орны олборлох салбарын талаар мэдлэг туршлагатай дотоодын мэргэжилтнүүд байв. Тэд санал шүүмжлэл гаргаж засвар өөрчлөлт хийхийг санал болгож, тайлбаруудыг хөндөхөөс гадна орхигдсон нотлох баримтуудаар хангаж алдаа дутагдлыг олж тогтоож байв. Улмаар хөндлөнгийн хянагч бүрийн санал шүүмжлэл зохих аргачлалын дагуу хийгдсэн, зөвшөөрч болох эсэхийг баталгаажуулан хянагдсан асуулгыг Орлогын ажиглагч институт (ОАИ)-д буцаан илгээж байлаа. Дараа нь санал шүүмжлэл бүрийг ахлах судлаачдаар судлуулан зохих хариуг өгч байв. Хэрэв хөндлөнгийн хянагчдын олсон нотлох баримт, санал болгосон зүйл нь тодорхой асуултуудын хариултыг өөрчлөхөд хүргэж байвал судлаачид зохих өөрчлөлтийг оруулж тэр тухай зохих тэмдэглэлийг хийж байсан. ОАИ-ийн ажилтнууд оноо тавих, онооны тухай эцсийн шийдвэр гаргахдаа улс орнуудын хэмжээнд хийсэн таамаглалуудын үнэн зөвийг шалгаж байсан. Эцэст нь, хянагч бүрийн санал болгосон өөрчлөлтийн тоо, хяналтын үйл явцын дараа оноо нь өөрчлөгдсөн асуултуудын тооны тухай мэдээллийг ОАИ цуглуулсан юм. Бид эдгээрийг тухайн онооны эцсийн тооцоог гаргах ажиллагааны цаана хэлэлцүүлэг, шийдвэр гаргах ажиллагаа явагдсаны баримт болгон харуулж байна (Хавсралт 3-г үзнэ үү). Хөндлөнгийн хяналтын ажиллагааг 2010 оны 2 дугаар сард эхэлж 7 дугаар сард дуусгасан. Үүний үр дүнд мэргэжилтэнд тулгуурласан судалгааны индекс гарсан бөгөөд өмнө тодорхойлсончлон бүх хариултыг нотлох баримтаар баталгаажуулсан юм.

## 2.5 Оноо өгөлт ба үр дүнгийн зохион байгуулалт

Дээр дурдсанчлан, Орлогын Ажиглагч Индекст зөвхөн ил тод байдалтай холбоотой асуултуудыг гол болгосон. Тус индекс нь асуулгыг бүрдүүлэгч долоон ангиллын дагуу хийгдсэн болно: Ангилал I -Нөөц баялагт хүрэх боломж, Ангилал II -Орлого бүрдүүлэлт, Ангилал III - Институцийн орчин, Ангилал IV - Газрын тос, байгалийн хий, уул уурхайн төрийн өмчит компаниуд, Ангилал V - Байгалийн баялгийн сангууд, Ангилал VI-Орон нутгийн шилжүүлэг, Ангилал VII -ОҮИТБС.

Оноо хуваарилахад хамгийн чухал хэсэг бол Орлого бүрдүүлэлтийн тухай ангилал II бөгөөд бусад бүх хэсгүүд нийлээд 22 шалгуур үзүүлэлттэй байхад энэ хэсэг 29 үзүүлэлттэй байна. Орлогын Ажиглагч Индекс нь санхүү, олборлох салбар хариуцсан

яамд, зохицуулах газрууд, төв банк, төрийн өмчит компаниуд (эсхүл холбогдох үүргийг гүйцэтгэж байгаа төрийн байгууллагууд) зэргийн мэдээллийг хамарсан таван багц асуултыг давтан асуудаг. Энэ загвар нь улс орон бүрийн мэдээллийн боломжит бүх эх сурвалжид иж бүрэн судалгаа хийх шаардлагыг гол болгосон болно. Орлогын Ажиглагч Индексийн энэ хэсгийн эцсийн онооны хувьд бид эдгээр таван багц эх сурвалжаас авсан үзүүлэлт бүрийн хамгийн дээд утгыг зориуд сонгож авсан. Энэхүү нэгдсэн оноо нь давтагдсан мэдээлэлд илүү оноо өгөхөөс зайлсхийдэг бөгөөд уг индексийн гол цөмийг бүрэлдүүлдэг[14].

Ангилал II-ын үзүүлэлтүүд нь тухайн улсын төсөв санхүүгийн тогтолцоон дахь олборлох үйлдвэрлэлийн нөлөөлөх чухал элементүүдийг онцолж байгаа ба газрын тос, байгалийн хий, ашигт малтмалаас Засгийн газрын авч байгаа төлбөрийн төрлүүд, тоо хэмжээг авч үзсэн. Уг индекст нөөц ашигласны төлбөр, тусгай татварууд, онцгой татвар, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүртэх орлогын хувь гэх мэт төлбөрийн бүхий л боломжит хэлбэрийг оруулдаг.

Олон нийтэд өгөх мэдээллийн нээлттэй байдал янз бүр байгаагаас хамаарч асуулт бүрт 0-100 хүртэл оноо өгсөн[15]. Эцсийн оноо нь ил тод байдалтай холбоотой асуултуудын авсан онооны энгийн дундаж юм. Бүх асуулт (олон сонголтот ба тийм/үгүй асуултууд) нь хариултдаа «аль нь ч биш» гэсэн боломжтой. Индекст ийм, «аль нь ч биш» гэсэн асуултад оноо өгөхөөс аль болохоор зайлсхийсэн ба  төрийн өмчит компани байдаггүй улс оронд ийм компани байгаа эсэх тухай асуулт гэх мэт үнэхээр аль нь ч биш гэж болохоор нөхцөл байдалд хэрэглэсэн болно. Хэрэв судлаач ийм асуултад оноо өгсөн бол хөндлөнгийн хянагч нь уг оноотой санал нэг байх шаардлагатай бөгөөд оноог эцэслэн гаргахын өмнө ОАИ-ээс байгаа нотлох баримтыг нь шалгасан. Мөн аливаа улсын Орлогын Ажиглагч Индексийн оноог тогтоохдоо «аль нь ч биш» гэсэн асуултуудыг холбогдох асуултын бүлгээс хасч байв.

## Улс орнуудын зэрэглэл

Индексийн эцсийн үр дүнд тулгуурлан улс орнуудыг байж болох 100 онооноос авсан харьцангуй дараалаар жагсааж үзвэл гурван бүлэгт хувааж болохоор байв:

- **Орлогын иж бүрэн ил тод байдал:** (дундаж оноо 67-100): энэ бүлгийн улс орнууд олборлох үйлдвэрлэлийнхээ менежментийн талаар үлэмж хэмжээний мэдээллийг иргэддээ өгдөг. Төрийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд нь тайлагналын практик маш сайтай, хариуцсан олборлох салбарынхаа чиглэл бүрээрээ задлан харуулсан, дэлгэрэнгүй мэдээллээр хангах хандлагатай байдаг.
- **Орлогын хэсэгчилсэн ил тод байдал:** (дундаж оноо 34-66): эдгээр орнууд олборлох салбарын тухай мэдээллээр иргэдээ хангадаг боловч тус индексийн нэг буюу түүнээс дээш чиглэлд ил тод байдлын ноцтой дутагдалтай байдаг.
- **Орлогын хязгаарлагдмал ил тод байдал:** (дундаж оноо 0-33): жагсаалтын энэ хэсэгт орсон улс орнууд иргэдээ мэдээллээр хамгийн бага хангадаг төдийгүй уг индекст хамрагдсан янз бүрийн ангилалд тайлагналын практик муутай байдаг.

Индекст хамрагдсан орнуудын үр дүн ихээхэн харилцан адилгүй байсан бөгөөд уг асуулга нь улс орон бүрийн хувьд тэргүүн туршлагаас хоцорч байгаа тодорхой чиглэлүүдийг тодруулж өгөхөд тустай байлаа. Иймээс Орлогын иж бүрэн ил тод байдлын бүлэгт орсон орнуудад ч гэсэн ангилал бүрт хамаарах тодорхой үзүүлэлтүүдийн оноог нарийвчлан шалгаж үзэхэд сайжруулах бодитой орон зай байгаа нь харагдаж байна.

## 2.6 Орлогын Ажиглагч Индекст юу хамрагддаггүй вэ?

Энэ индекс бол авлига, эсхүл төсвийн нээлттэй байдлын хэмжүүр биш. Эдгээр асуудлаар тайлан гаргадаг өөр бусад нэр хүндтэй, тогтсон байгууллагууд байдаг. Эдгээр сэдвийг сонирхсон уншигчид Транспэрэнси Интерэйшнлийн Авлигын ухамсрын индекс, Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн индекс (НТИ), Глобал Интегрити байгууллагын Дэлхий нийтийн шударга ёсны тайлан, Дэлхийн Банкны Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд зэргийг үзэх хэрэгтэй. Харин энэ индекс нь засаглалын харьцуулсан үзүүлэлтүүдийн өнөөг хүртэл орхигдуулж ирсэн онцгой нэг салбар болох олборлох үйлдвэрлэлд зориулсан шинэ хэмжүүрийг танилцуулж байна.

Үүний нэг адилаар энэ индекс нь аливаа улсын олборлох үйлдвэрлэл улс орныхоо эдийн засгийн өсөлт, хөгжилтөд үр дүнтэй хувь нэмэр оруулж байгаа эсэхийг хэмждэггүй. Мөн тайлагнасан болон олж тогтоосон мэдээллийнхээ үнэн зөв, эсхүл иж бүрэн байдалд голлон анхаардаггүй. Төсвөөс гадуурх, тайлагнагдаагүй далд гүйлгээнд оролцсон байж болох орнууд энэ судалгаанд хэрэглэсэн аргачлалаар тогтоогдохгүй байж болно. Иймд энэ судалгаанд үндэслэн үүссэн аливаа маргааныг бидний анхан шатны баримт бичиг, тайлангуудаар баталж болох мэдээллээр хязгаарлах хэрэгтэй. Үүний зэрэгцээ, тус индексийн ирээдүйд хийгдэх судалгаагаар албан ёсны эх сурвалжуудын өгч байгаа мэдээллийн баттай, үнэн зөв байдлыг шалгаж болох бөгөөд үүнд тоон мэдээлэл цуглуулах, эсхүл олон улсын, эсхүл хараат бус эх сурвалжуудын мэдээлэлтэй тулгаж үзэх ажиллагаа орж болно.

Энэхүү индекс нь улс орнуудыг харьцуулах суурь бий болохын зэрэгцээ тэд олборлох үйлдвэрлэлийнхээ ил тод байдлыг улам сайжруулах боломжуудыг ашиглаж байгаа эсэх, хэрхэн ашиглаж байгааг үнэлэх хэрэгслээр хангадаг. Мөн энэ индексийн харьцангуй чанар, бодлогын түвшинд чиглэсэн онцлог нь бодлого боловсруулагчдын хувьд институцийнхээ ажиллагаанд үнэлэлт өгөх, нөлөөллийн байгууллагуудын хувьд шинэтгэл хийх шаардлагатай тодорхой чиглэлүүдийг нарийн томъёолж гаргах хүчирхэг хэрэгслээр хангадаг байна.

Аливаа улсын институцийн практик болон засаглалын бүх хэмжээсүүдийг гаргаж чадах хэмжүүр гэж байхгүй. Гэхдээ Орлогын Ажиглагч Индекс нь энэхүү аргачлалд тайлбарласан төсөөлөл, дүрмийн дагуу олдсон хамгийн сайн мэдээллээр хангаж байна. Энэ индекс бол аливаа улсын засаглалын иж бүрэн тойм биш, харин өнөөг хүртэл үл хайхарч ирсэн тодорхой нэг салбарын үзүүлэлтийг хэмжиж байгаа юм.

## Гол баримт бичгүүд

Бид Олон Улсын Төсвийн Түншлэл (ОУТТ) байгууллагын Нээлттэй Төсвийн Индекстэй ижил төстэй стандарт ашиглан аль нэг иргэн, эсхүл нийт иргэд тухайн баримт бичгийг боловсруулан гаргаж байгаа төрийн байгууллагад хүсэлт гаргах замаар олж авч болох мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэл гэж тодорхойлсон. Мэдээлэл цуглуулах ажиллагааны явцад судлаачид дараах баримт бичгийг шалгаж байлаа:

- **Гэрээ буюу хөрөнгө оруулалтын гэрээнүүд:** Төр (эсхүл түүнийг төлөөлсөн эрх бүхий аль нэг байгууллага) ба олборлогч компаниудын хооронд байгуулсан нөөц ашиглалтын гэрээнүүд. Эдгээрийг гол төлөв олборлох үйлдвэрлэл хариуцсан яам, эсхүл төрийн өмчит компаниас гаргаж нийтэлдэг.
- **Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ:** олборлох салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх нөлөөний тухай мэдээлэл агуулсан үнэлгээнүүд. Эдгээрийг төрийн өмчит компани, эсхүл байгаль орчны яамд гаргаж нийтлэх хандлагатай байдаг.
- **Статистикийн мэдээ/мэдээллийн сан:** олборлох үйлдвэрлэлтэй холбоотой статистик мэдээлэл агуулсан баримт бичгүүд. Ер нь статистикийн мэдээ тайлангуудыг олборлох үйлдвэрлэл хариуцсан яам, статистикийн газар, зохицуулалтын агентлаг эсвэл ТӨК-ууд гаргадаг.
- **Жилийн болон явцын дундах тайлан:** аливаа улсын засгийн газраас олборлох үйлдвэрлэлийн талаар хийж байгаа үйл ажиллагааг харуулсан жил, улирал, сар тутмын баримт бичгүүд. Эдгээрийг ихэвчлэн төрийн байгууллагууд гаргадаг бол зарим оронд төв банк нь олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр хийж байгаа үйл ажиллагаагаа тайлагнадаг.
- **ОҮИТБС-ын тайлан:** аливаа улсын газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбараас орж байгаа орлогыг агуулсан баримт бичгүүд. Эдгээрийг ихэвчлэн ОҮИТБС-ын тайлан хариуцсан хараат бус байгууллага бичдэг бөгөөд тухайн улсын олон сонирхогч талын бүлэг хүлээн авч баталдаг[16].
- **Аудитын тайлан:** нэг бол төрийн байгууллагын жилийн эцсийн тайлан тооцоог шалгадаг Аудитын дээд байгууллагаас (АДБ) гаргасан жилийн тайлан, эсхүл ТӨК-иудын юмуу, нөөц баялгийн орлогыг удирдан зохицуулдаг байгууллагын санхүүгийн тайланд аудит хийдэг хөндлөнгийн эсвэл дотоод аудитын байгууллагуудын тайлан[17].

## 2.7 Орлогын Ажиглагч Индексийн тухай судалгаагаар тогтоосон гол баримт бичгүүд

Тус индексийн судалгаагаар олон тооны үнэ цэнэтэй мэдээлэл, баримт бичгийг олж тогтоосон. Албан ёсны үндсэн баримт бичгүүдийг «Гол баримт бичгүүд» гэж үзсэн бөгөөд эдгээр нь Орлогын Ажиглагч Индексийн оноог тогтоох үндсэн нотлох баримтууд юм. Эдгээр баримт бичгийг тодорхойлохдоо ОУВС-гийн удирдамж, ОҮИТБС болон олон улсын бусад холбогдох стандартад тулгуурласан болно[18].

Гол баримт бичгүүдийг тогтоохоос гадна Орлогын Ажиглагч Индексийн судалгаанд засгийн газраас өгч байгаа гол баримт бичгүүдийн олон нийтэд нээлттэй байдлын түвшинг тогтоосон. Энэ мэдээллийг хүснэгт 1-д нэгтгэн харуулав. Судлаачдын олж өгсөн баримт бичгүүд бол тухайн улс орнууд гол баримт бичгүүдээ боловсруулан гаргаж, олон нийтэд бодитойгоор түгээж байгаагийн нотлох баримт юм. Хүснэгтийн бусад гурван ангилалд орсон бидний таамаглалыг дотоодын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага хамтран хянагчдын өгсөн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

Хүснэгт 1-д гэрээний ил тод байдал маш ховор байдгийг харуулж байна. Ашигт малтмалын нөөцийнхөө гэрээнүүдийг бүрнээр нь нийтэлсэн тавхан засгийн газар байна. Харин Сангийн яам, газрын тос, эсхүл уул уурхайн яамдаас гаргасан жилийн тайлан, статистик мэдээ тайлангууд нилээд түгээмэл байна. Байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх нөлөөний үнэлгээний хувьд дийлэнх засгийн газрууд энэ төрлийн мэдээлэл агуулсан баримт бичгүүдээ нийтэлдэггүй ажээ.

ХҮСНЭГТ 1

**ГОЛ БАРИМТ БИЧГҮҮДИЙГ ОЛЖ АВАХ БОЛОМЖ**

| Countries producing | Баримт бичгүүдийг боловсруулан гаргаж, олон нийтэд түгээж байгаа (номын сан, сонин, онлайн гэх мэт) улсууд | Баримт бичгүүдийг боловсруулан гаргадаг, гэхдээ зөвхөн хүсэлт тавьсан тохиолдолд олон нийтэд өгдөг улсууд | Баримт бичгүүдийг зөвхөн дотоод хэрэгцээнд зориулан гаргадаг боловч нийтийн хүртээл болгодоггүй улсууд | Баримт бичгүүдийг дотоод хэрэгцээндээ ч зориулж гаргадаггүй улсууд |
|---|---:|---:|---:|---:|
| Гэрээнүүд[19] | 5 | 4 | 21 | 3 |
| Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ | 15 | 6 | 5 | 15 |
| Статистик тайлангууд/ мэдээллийн сан | 38 | 0 | 0 | 3 |
| Жилийн тайлангууд | 39 | 0 | 0 | 2 |
| Явцын дундах тайлангууд[20] | 30 | 1 | 1 | 8 |
| ОҮИТБС-ын тайлангууд | 18 | 0 | 0 | 23 |
| Аудитын тайлан, дүгнэлтүүд | 22 | 3 | 8 | 8 |

# 3 Ерөнхий үр дүн

Орлогын Ажиглагч Индексээс үзэхэд эдгээр улс орнуудын дөрөвний гурав нь (41-ээс 29) олборлох үйлдвэрлэлийнхээ талаар маш бага юмуу, хэсэгчилсэн мэдээллээр хангаж байна. Энэ нь улсын өмчийн байгалийн баялгийн олборлолтоос засгийн газар нь хэр их ашиг орлого олж байгаа тухай гол чухал мэдээлэл иргэдэд байхгүй байна гэсэн үг.

Хүснэгт 2 (хуудас 16)-т улс орнуудын зэрэглэлийг Орлогын Ажиглагч Индекст орсон мэдээллийн төрлөөр задалж харуулав. Үүний дараа ангилал бүрийн дэлгэрэнгүй танилцуулгыг оруулсан болно.

### 3.1 Орлогын иж бүрэн ил тод байдал

*Индексийн дээд хэсэгт багтсан орнуудад сайжруулах орон зай байсаар байна.*

Энэ ангилалд орсон 12 улс орлогоо хүлээн авсан төрийн байгууллага, төрийн өмчит компани бүрээр задлан харуулсан харьцангуй дэлгэрэнгүй мэдээллээр хангаж байна. Энэ бүлгийн орнууд Орлогын Ажиглагч Индекст дунджаар 81 оноотой, зарим нэг нийтлэг онцлогтой. Тэд баялгийн нөөц, үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ өртөг, тухайн улсад ажиллаж байгаа компаниудын тухай мэдээллээс гадна нөөц ашигласны төлбөр, орлогын болон онцгой татвар гэх мэт засгийн газарт төлж байгаа үндсэн төлбөрүүдийн тухай мэдээллийг ил болгосон байна. Тухайн улсын төрийн сан, татвар, статистикийн газруудад тайлагналын практик сайн хэвшсэн болохыг тус индексийн судалгаагаар тогтоожээ. Олон тооны төрийн байгууллага өөрсдийн хариуцсан янз бүрийн чиглэлээр нарийвчилсан, задалж ангилсан тайлан мэдээгээр хангаж байна. Түүнчлэн эдгээр улсын төрийн өмчит хэд хэдэн компани хэдийгээр төрийн хяналт давамгайлдаг ч гэсэн хөрөнгийн биржид бүхэлдээ, эсхүл хэсэгчилсэн байдлаар бүртгэгдсэн, улмаар хөрөнгө оруулагчиддаа зориулсан нээлттэй тайлан гаргадаг ажээ.

Энэ ангиллын жагсаалтыг Бразил Улс тэргүүлж, Чили, Норвеги хоёроос арай өндөр оноо авсан бөгөөд энэ хоёр улс ч гэсэн газрын тос, байгалийн хий, уул уурхайн сайн засаглалын загварт тооцогддог. Казахстан, Орос улсууд татварын болон статистикийн байгууллагынхаа тайлан мэдээллийн үр дүнд энэ ангилалд багтаж байна. Мексикийн Сангийн болон Эрчим хүчний яамд төдийгүй бүхэлдээ төрийн өмчийн мэдэлд байдаг боловч олон улсын ба үндэсний хөрөнгийн зах зээл дээр бонд гаргах ажиллагаар хэдэн жилийн турш амжилттай зохион байгуулж байгаа газрын тосны үндэсний компани (ГТҮХ) нь дэлгэрэнгүй тайлан мэдээллээр хангадаг байна. Колумб Улс ч тус салбарын байгууллагуудынхаа хэмжээнд тайлагналын сайн практик хэвшүүлжээ. Перу Улс мэдээлэл авах боломжоор хангах, тайлагналын практик нэвтрүүлэх тал дээр бүс нутагтаа анхдагч нь болоод байгаа бөгөөд ахиц дэвшил нь ч зэрэглэлээс нь харагдаж байна. Америкийн Нэгдсэн Улсын Эрдэс баялгийн менежментийн алба энэ салбараа зохицуулж, хүчин төгөлдөр байгаа түрээсийн гэрээ, төлбөртэй холбоотой мэдээллийг бүрэн хэмжээгээр нийтэлдэг[21]. Эцэст нь, Зүүн Тимор Улс төр улсаа тохинуулах ажлын нэг хэсэг болгож ил тод байдлын өндөр хэм хэмжээг нэвтрүүлээд байна.

Хэдийгээр уг индексийн жагсаалтын дээд хэсэгт бичигдсэн ч гэсэн эдгээр орнуудад цаашид сайжруулж хийх зүйл байсаар байна. Орлогын ил тод байдалд ахиц дэвшил гаргахын тулд мэдээллийн задаргааны түвшинг өргөжүүлж нөөц ашигласны төлбөр, онцгой татварууд, бонус, бүтээгдэхүүн хуваах гэрээнээс (БХГ) хүртэх хувь, газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт орж байгаа бусад холбогдох төлбөр хураамж зэрэг бүх төлбөрийг оруулж болно. Эдгээр мэдээллийг нийтэд хялбар дөхөм хүртээмжтэй хэлбэр, эх сурвалжаар өгөх нь тайлагналт, задлан шинжилгээний ажлыг хөнгөвчилнө. Мөн ТӨК-иудын үйл ажиллагааг хяналт шалгалтад нээлттэй болгох, засгийн газраас олборлолтын компаниудтай тохиролцсон төсөв санхүүгийн нөхцлүүдийн тухай мэдээллээр хангах, ялангуяа ийм гэрээг бүрэн ил болгох тал дээр сайжруулалт хийх боломжтой. Эцэст нь, Орлогын Ажиглагч Индекст энэ бүлгийн улсууд ОҮИТБС-ын үндсэн шалгуурыг хэдийн хангасныг харуулдаг учраас ОҮИТБС-ын хэрэгжүүлэлтэд анхаарч, улмаар баталгаажуулалтын ажиллагааны дараа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөнийхөө үр шимийг үргэлжлүүлэн хүртэх боломжтой юм.

ХҮСНЭГТ 2

**ОРЛОГЫН АЖИГЛАГЧ ИНДЕКСИЙН ҮР ДҮН, МЭДЭЭЛЛИЙН ТӨРЛӨӨР**

| Улс | 1. Нөөц баялагт хүрэх боломж | 2. Орлого бүрдүүлэлт | 3. Институтын орчин | 4. Төрийн өмчийн компаниуд | 5. Байгалийн баялгийн сангууд | 6. Орон нутгийн шилжүүлэг | 7. ОҮИТБС | Орлогын Ажиглагч Индекс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бразил | 91.8 | 100.0 | 100.0 | 100.0 | Байхгүй | 100.0 | 0.0 | 97.0 |
| Норвеги | 91.8 | 97.0 | 100.0 | 100.0 | 100.0 | Байхгүй | 67.0 | 96.4 |
| Орос | 89.0 | 93.1 | 67.0 | 81.0 | 100.0 | 100.0 | 0.0 | 89.7 |
| Мексик | 83.3 | 79.0 | 100.0 | 94.5 | 91.8 | 100.0 | 0.0 | 83.4 |
| Чили | 66.7 | 84.0 | 100.0 | 95.3 | 91.8 | 53.2 | 0.0 | 80.6 |
| Колумб | 100.0 | 80.3 | 100.0 | 85.7 | 33.3 | 100.0 | 0.0 | 79.6 |
| Казахстан | 44.3 | 93.8 | 67.0 | 66.7 | 91.8 | 0.0 | 67.0 | 77.5 |
| Перу | 75.0 | 71.2 | 100.0 | | | 100.0 | 67.0 | 76.8 |
| Азербайжан | 33.3 | 76.3 | 33.0 | 77.8 | 100.0 | | 100.0 | 75.1 |
| Эквадор | 58.3 | 76.0 | 100.0 | 76.1 | | 80.0 | 0.0 | 73.6 |
| АНУ | 100.0 | 63.4 | 100.0 | | 75.0 | 86.6 | 0.0 | 71.4 |
| Зүүн Тимор | 58.3 | 69.5 | 100.0 | 0.0 | 100.0 | | 67.0 | 70.5 |
| Ирак | 41.8 | 68.0 | 67.0 | 50.0 | 91.8 | 60.0 | 33.0 | 63.8 |
| Венесуэл | 11.0 | 70.7 | 100.0 | 71.6 | 33.3 | 73.2 | 0.0 | 63.0 |
| Тринидад ба Тобаго | 58.3 | 64.2 | 100.0 | 85.7 | 91.8 | 0.0 | 0.0 | 61.9 |
| Йемен | 33.3 | 70.5 | 67.0 | 38.8 | | | 33.0 | 60.5 |
| Либери | 75.0 | 63.8 | 67.0 | | 0.0 | | 100.0 | 60.5 |
| Өмнөд Африк | 33.3 | 62.1 | 100.0 | | | | 0.0 | 58.0 |
| Болив | 25.0 | 53.1 | 100.0 | 66.6 | | 86.6 | 0.0 | 56.3 |
| Папуа-Шинэ Гвиней | 66.8 | 51.3 | 100.0 | 71.4 | 0.0 | 20.0 | 0.0 | 51.1 |
| Индонез | 58.3 | 52.4 | 67.0 | 33.3 | | 60.0 | 0.0 | 50.0 |
| Малайз | 11.0 | 64.1 | 33.0 | 33.3 | 100.0 | 0.0 | 0.0 | 48.4 |
| Нигери | 25.0 | 47.4 | 67.0 | 52.3 | 0.0 | 80.0 | 67.0 | 46.5 |
| Ботсван | 25.0 | 56.0 | 100.0 | 23.7 | 44.3 | | 0.0 | 46.3 |
| Хятад | 33.3 | 44.4 | 67.0 | 71.4 | | 0.0 | 0.0 | 42.2 |
| Габон | 25.0 | 49.2 | 67.0 | | 41.8 | 0.0 | 67.0 | 41.8 |
| Камерун | 58.3 | 46.0 | 67.0 | 57.1 | 0.0 | 0.0 | 67.0 | 41.8 |
| Замби | 33.3 | 42.0 | 67.0 | 40.0 | | | 33.0 | 41.2 |
| Сьерра Леоне | 41.5 | 39.1 | 100.0 | | | 6.6 | 100.0 | 38.2 |
| Монгол | 50.0 | 38.4 | 67.0 | 42.9 | 25.0 | 20.0 | 67.0 | 38.2 |
| Судан | 0.0 | 36.6 | 0.0 | 26.6 | 50.0 | 86.6 | 0.0 | 37.4 |
| Иран | 44.3 | 43.2 | 33.0 | 42.7 | 16.5 | 6.6 | 0.0 | 36.1 |
| Ангол | 41.8 | 44.4 | 67.0 | 38.8 | 0.0 | 0.0 | 0.0 | 34.7 |
| Саудын Араб | 0.0 | 36.0 | 33.0 | 27.7 | 49.8 | | 0.0 | 32.4 |
| Гана | 25.0 | 33.3 | 67.0 | 100.0 | 0.0 | | 67.0 | 32.3 |
| Кувейт | 0.0 | 30.3 | 33.0 | 51.6 | 25.0 | | 0.0 | 29.8 |
| Танзани | 25.0 | 27.8 | 100.0 | 16.7 | | | 33.0 | 27.8 |
| Алжир | 25.0 | 23.8 | 33.0 | 42.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 22.8 |
| БНАКУ | 11.0 | 13.8 | 100.0 | 66.7 | | 20.0 | 67.0 | 22.5 |
| Эквадорын Гвиней | 41.8 | 12.3 | 67.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 11.6 |
| Туркменистан | 0.0 | 16.7 | 33.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 9.7 |
| **Дундаж** | **44.8** | **53.9** | **74.0** | **54.3** | **46.3** | **45.2** | **26.9** | **51.8** |

Орлогын Ажиглагч Индексийг 51 үзүүлэлтийн дунджаар тооцдог бөгөөд харин мэдээллийн төрлөөр задлан шинжилсэн энэхүү долоон ангиллын дундаж биш гэдгийг анхаараарай. Тайлангийн мэдээллийг үзэх буюу татаж авахыг хүсвэл www.revenuewatch.org/rwindex хаягаар хандана уу.

## 3.2 Орлогын хэсэгчилсэн ил тод байдал

Энэ бүлгийн хамгийн доод хэсэгт байгаа таван орон ангилал бүрт мэдээллийг харилцан адилгүй ил болгож байна. Энэ ангилалд 34-66 оноо авсан 21 улс багтаж дунджаар 48.5 оноо авчээ. Гэхдээ энэ бүлгийн орнууд дотор мэдээллийг ил болгох байдал ихээхэн ялгаатай байна. Энэ ялгааг тодруулахын тулд бид гурван түвшинд хуваав. Үүнд 60-аас дээш оноотой тав, 41-59 оноотой 11, 40-өөс дээш оноотой таван улс байна.

Энэ бүлгийн хамгийн өндөр оноотой хэсэгт Ирак, Либери, Тринидад ба Тобаго, Венесуэл, Йемен улсууд оржээ. Хэдийгээр Ирак, Йемен улсууд орлого бүрдүүлэлтийн тайлан мэдээгээрээ дунджаас дээгүүр оноо авсан боловч нөөц баялагт хүрэх боломж, төрийн өмчит компаниудын талаарх мэдээллээрээ доогуур түвшинд байсан байна. Либери улс ОҮИТБС-ын үйл явцаараа дамжуулж өргөн хүрээтэй мэдээлэл нийтэлж байна. Тринидад ба Тобаго Улс тайлагналын ерөнхий чадавхи сайтай боловч орон нутгийн шилжүүлгүүдээ тайлагнадаггүйгээс оноо нь доошилсон байна. Венесуэл Улсын хувьд орлого бүрдүүлэлтийн тайлагналт сайтай боловч албан ёсны тоо баримтын чанарын хувьд өмнө нь асуудалтай байжээ[22]. Гэхдээ Орлогын Ажиглагч Индекс энэ хүчин зүйлийг үүсгэгч тоо баримтуудыг шалгаагүй бөгөөд олон нийтэд нээлттэй байгаа мэдээллийг гол болгож сонгосон болно.

*Энэ бүлгийн хамгийн доод хэсэгт байгаа таван орон ангилал бүрт мэдээллийг харилцан адилгүй ил болгож байна.*

Эдийн засгийн хөгжил, газар зүйн байрлал, улс төрийн тогтолцооны хувьд нилээд ялгаатай 11 улс энэхүү ангиллын дунд хэсэгт багтжээ. Өмнөд Африк, Ботсван улсууд энэхүү үнэлгээнд орсон Африкийн хамгийн өндөр оноотой улс боловч орлого бүрдүүлэлтийн мэдээллээ дундаж хэмжээнд тайлагнасан байна. Энэ ангиллын 11 улсын дөрөв нь буюу Камерун, Габон, Нигери, Замби улсууд ОҮИТБС-ыг хэрэгжүүлдэг. Гэвч тэд бусад үзүүлэлтээрээ дундаж, эсхүл дунджаас доош дүнтэй байна. Үлдэж байгаа Болив, Хятад, Индонез, Малайз, Папуа-Шинэ Гвиней улсууд орлого бүрдүүлэлтийн мэдээллээрээ дунджаас доогуур оноотой гарчээ.

Энэ бүлгийн хамгийн доод хэсэгт байгаа таван орон ангилал бүрт мэдээллийг харилцан адилгүй ил болгож байна. Тэдний хоёр нь (Монгол, Сьерра Леоне) ОҮИТБС-ын гишүүд. Судан Улс ихэнх ангилалд маш бага оноо авсныг эс тооцвол орлого бүрдүүлэлтийн талаар болон Суданы өмнөд хэсэгт шилжүүлсэн орлогынхоо талаархи зарим мэдээллийг ил болгосон байна[23]. Энэ ангилалд сүүл мушгиж байгаа Ангол Улс газрын тосны үндэсний компани болон байгалийн баялгийн сангийнхаа талаархи мэдээллээр муу хангадаг байна.

## 3.3 Орлогын хязгаарлагдмал ил тод байдал

Дунджаар 23.6 оноотой найман орноос бүрдсэн энэ бүлгийн орнуудын нийтлэг онцлог бол орлого бүрдүүлэлтийн тайлан муутай, нөөц баялагт хүрэх боломж нь ил тод бус байдагт оршино. Энэ хоёр чиглэлийн мэдээллээ ил болгохдоо тааруухан байдал нь ОҮИТБС-д оролцогч БНАКУ, Экваторын Гвиней, Гана, Танзани улсуудын оноог доош татжээ. Гана, Танзани зэрэг зарим улс байгалийн баялгийн сангуудын ил тод байдал, институцийн орчны зарим үзүүлэлтдээ дунджаас дээш оноо авсан боловч индекст хамрагдсан салбаруудаас засгийн газарт орсон төлбөрүүдийн тухай мэдээллээр тааруухан хангадаг, эсхүл цаг алдалгүй өгч чаддаггүй нь тэднийг хойш татжээ. Энэ ангиллын бусад дөрвөн улс болох Алжир, Кувейт, Саудын Араб, Туркменистан улсууд энэ яригдсан сэдвүүдээр огт мэдээлэл өгдөггүй бөгөөд энэ нь Нээлттэй Төсвийн Индекс гэх мэт ил тод байдлын бусад хэмжүүрт доогуур зэрэглэлд ордогтой нь нийцэж байна.



## СТАТИСТИК ТОО БАРИМТ

Гэрээнүүдээ иж бүрэн нийтэлдэг судалгаанд хамрагдсан улс:

5

---

Олон нийтийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулдаг орнууд:

12

---

Байгаль орчинд үзүүлэх нөлөөний зарим үнэлгээг нийтэлдэг орнууд:

15

---

Төрийн өмчийн газрын тос, байгалийн хий, уул уурхайн **компанигүй**, судалгаанд хамрагдсан улсын тоо:

1

# 4 Ангилал бүрийн үр дүн

## 4.1 Нөөц баялагт хүрэх боломж

Энэ ангиллын шалгуурт доогуур оноо авна гэдэг бол иргэддээ мэдээлэл авах боломж олгохгүй, газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбар дахь томоохон хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг олон нийтэд ил болгохгүй байна гэсэн үг. Орлогын Ажиглагч Индекс нь Гэрээний нууцлалын тухай тус индексийн 2009 оны тайланд олж мэдсэн зүйлсээ үргэлжлүүлэн судалж үзэхэд тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх нөлөөний үнэлгээ, гэрээ хэлэлцээрүүд олон нийтийн хяналтаас гол төлөв гадуур үлддэг нь харагдаж байна[24].

Мөн энд олж мэдсэн зүйлс нь гэрээний ил тод байдал маш доогуур байдгийг харуулж байна.  Судалгаанд хамрагдсан орнуудын дотроос зөвхөн Колумб, Либери, Перу, Зүүн Тимор, Америкийн Нэгдсэн Улс зэрэг улсууд хүчин төгөлдөр байгаа гэрээнүүдээ бүрэн нийтэлдэг байна[25].  Гэрээний ил тод байдал тун амархан алдагдах аюултай байж болох юм. Тухайлбал, Болив Улс гэрээ хэлэлцээрүүдээ ил болгон тавьдаг байсан Засгийн газрын вэб хуудсаа 2010 оны эхээр хаасан байна. Зарим тохиолдолд, засгийн газар нь биш үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд гэрээгээ нийтэлдэгийг Азербайжаны жишээ харуулсан юм.

Энэ индекст тааруухан үнэлгээ авсан Экваторын Гвиней, Судан, Туркменистан зэрэг улсын засгийн газар хийсэн гэрээнүүдээ хууль тогтоох байгууллагадаа ч тайлагнадаггүй байна. Мөн ихэнх орнуудад улсынхаа олборлох үйлдвэрлэлийн талаар мэдээлэл авах эрхийг иргэддээ олгосон хууль тогтоомж, дүрэм журам дутагдаж байна. Ялангуяа, мэдээллийн эрх чөлөөгөөр хамгийн муу орнуудын тоонд байгалийн баялгаас хамгийн их хамааралтай байдаг Кувейт, Саудын Араб, Судан улсууд ордог бөгөөд эдгээр улсын төсвийн орлогын дийлэнх хувь нь газрын тос, байгалийн хий, уул уурхай үйлдвэрлэлийн орлого байдаг. Судалгаанд хамрагдсан орнуудын дөнгөж 12 нь мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, олон нийтийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах хууль баталсан байдаг гэж үзвэл нөхцөл байдал бүр ч цочирдмоор ба энэ улсуудын найм нь дэлхийн бөмбөрцгийн баруун хэсэгт оршдог байна.

Тусгай зөвшөөрөл олгох журмын тухай мэдээллийг ил болгох явдал гэрээнүүдийг бодвол илүү түгээмэл  байдаг бөгөөд энэ сэдвээр зарим нэг мэдээлэл нийтэлдэг 22 улс  (тэдний бараг тэн хагас нь газрын тосоор баян) байна.  Үүний гол шалтгаан бол нүүрс устөрөгчийн үйлдвэрлэлийн салбарт хайгуулын болон ашиглалтын эрхийг хуваарилах, үйлчилгээ үзүүлэгчдийг шалгаруулахдаа дуудлага худалдааны аргыг өргөнөөр хэрэглэдэгтэй холбоотой. Нөгөө талаас, тус индексийн судалгаанд хамрагдсан уул уурхайн компаниудын дийлэнх нь тусгай зөвшөөрлийн эрх авахдаа «эхэлж ирсэн нь эхэлж үйлчлүүлэх» зарчмыг мөрддөг байна. Уул уурхайн тухай хууль тогтоомждоо тодорхой, урьдчилан таамаглаж болохуйцаар заасан ч гэсэн  энэ төрлийн ажиллагаа нь дуудлага худалдааг бодвол илүү ил тод бус байдаг.

Өөр нэг чухал асуудал бол байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх нөлөөний үнэлгээг засгийн газраас нийтлэх явдал юм. Энэ индекст хамрагдсан 15-хан улс л (нефть үйлдвэрлэгч ес, эрдэс баялаг үйлдвэрлэгч зургаан улс) байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөний зарим үнэлгээгээ нийтэлсэн байна. Зарим тохиолдол энэ нь төрийн өмчийн компаниудын нийгмийн хариуцлагын хэлбэрээр илэрдэг. Энэхүү индексээр тогтоогдсон олон янзын туршлагаас үзэхэд, эдгээр тайланг боловсруулан гаргаж, нийтлэхтэй холбоотой дэлхий нийтийн стандарт шинээр төрөн гарсаар байгаа нөхцөлд засгийн газрууд байгаль орчны асуудлуудын талаарх мэдээллээ хэрхэн тайлагнах талаар үргэлжлүүлэн судлах нь чухал болохыг харуулж байна[26].

## 4.2 Орлого бүрдүүлэлт[27]

Улс орнуудын нийтлэн гаргаж буй мэдээллийн төрлийг нарийвчлан задлан шинжилж үзэхэд засгийн газрууд санхүүгийн мэдээллээсээ илүү үйл ажиллагааны мэдээллээ илээр тайлагнах хандлагатай байна. Баялгийн нөөц, үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, өртөг зардал, тухайн улсад ажиллаж байгаа компаниуд, үйлдвэрлэлийн хэмжээний задаргаа зэргийг нийтлэх тал дээр Бразил, Чили, Колумб, Мексик, Норвеги, АНУ зэрэг улсууд хамгийн өндөр үнэлгээ авчээ. Энэ хэсгийн нийт дундаж оноо 67.7, энэ чиглэлээр авсан хамгийн бага оноо 25.8 (Хүснэгт 3) байна[28].

Нөгөө талаас, бүтээгдэхүүн хуваах гэрээнээс хүртэх ашгийн хувь, нөөц ашигласны төлбөр, онцгой татвар, ногдол ашиг, бонус, олборлолтын хураамж гэх мэт засгийн газарт хүлээн авч буй санхүүгийн төлбөрүүдийн задаргаа мэдээллийг ил болгож тайлагнах магадлал бага байдаг. Энэ талаар улс орнуудын авсан дундаж оноо 46.7 байсан ба энэ төрлийн мэдээллээ огт нийтэлдэггүй зургаан улс байна.

*Үйл ажиллагааны талаарх тоо баримтыг тайлагнах явдал илүү түгээмэл байдаг нь тухайн улсад орох хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих арга зам гэж засгийн газрууд үздэгтэй холбоотой.*

Үйл ажиллагааны талаархи тоо баримтыг тайлагнах явдал илүү түгээмэл байдаг нь тухайн улсад хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих арга зам гэж засгийн газрууд үздэгтэй холбоотой. Тухайн улсын баялгийн нөөц, үйлдвэрлэл болон нийт хөрөнгө оруулалтын хэмжээг нийтлэх нь ирээдүйн үйлдвэрлэлийн чадавхийг болон санхүүгийн итгэл даах чадварын илрэл байдаг. Үйл ажиллагааны мэдээллийг ил болгодог хоёр дахь шалтгаан бол улс орнууд төрийн өмчийн компаниудаа, ялангуяа нүүрс устөрөгчийн буюу нефтийн салбарт ажилладаг компаниудаа, хөрөнгийн биржээр олон нийтэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн арилждаг, ядаж л үнэт цаасны зах зээл дээр бонд гаргадаг болсон чиг хандлага юм. Ийм зохицуулалтын жишээнд Бразил, Казахстан, Мексик, Оросын төрийн өмчит (буюу төрийн мэдлийн) компаниуд орно. Төрийн өмчийн компаниуд санхүүгийн зах зээлд оролцох нь нэмэгдсэнээр тэд үйл ажиллагаанызаа болон санхүүгийнхээ тухай бодитой мэдээллийг хөрөнгө оруулагчиддаа тайлагнах үүрэгтэй болгож байна.

Улс орнууд олборлосон нөөц баялгаасаа олж байгаа төлбөрүүдийг тогтооход санхүүгийн мэдээлэл амин чухал үүрэгтэй. Энэ бол газрын тос, эрдэс баялгаас олж байгаа ашигтаа анхаарал хандуулахаас өмнө зайлшгүй хийх ёстой алхам юм. ОҮИТБС болон Төлснөө нийтэл кампанит ажилд шаарддагчлан энэ бол хариуцлагатай байдлын нэг салшгүй тал бөгөөд засгийн газрууд мэдээллээ, түүний дотор олборлох салбараас олж байгаа төлбөрийн төрөл бүрийнхээ дэлгэрэнгүй мэдээллийг ил болгож, тайлагнах тэргүүн туршлагуудыг мөрдлөг болгох ёстой.

Түүнчлэн орлого бүрдүүлэлтийн хэсэгт тайлагналын чанар, давтамжид үнэлгээ өгдөг. Тайлагналын чанар гэж тайлангаа иж бүрэн, ойлгомжтой гаргасан эсэхийг хэлэх бөгөөд давтамж нь уг тайлангуудаа хэр олон удаа гаргадаг болохыг харуулдаг. Ерөнхийдөө судалгааны энэ үр дүнг төрийн байгууллагуудаар ялган харуулвал эдгээр ангиллуудын хооронд мэдэгдэхүйц ялгаатай байгаа нь харагдана (Хүснэгт 4).

ХҮСНЭГТ 4

**ТАЙЛАНГИЙН ЧАНАР, ДАВТАМЖИЙН ОНОО**

| Байгууллага | Давтамж | Тайлангийн чанар | Дундаж |
|---|---:|---:|---:|
| Төв банк | 68.4 | 68.5 | 68.4 |
| Олборлох үйлдвэрлэлийн яам | 36.3 | 45.8 | 41.3 |
| Сангийн яам | 59.4 | 58.8 | 59.1 |
| Зохицуулагч агентлаг | 29.6 | 31.0 | 30.3 |
| Төрийн өмчийн компани | 41.0 | 56.3 | 48.7 |
| **Дундаж** | **48.6** | **53.3** | **51.0** |

ХҮСНЭГТ 3

**II АНГИЛЛЫН ОНОО, – ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ БА ТАЙЛАГНАСАН МЭДЭЭЛЛИЙН ТӨРЛӨӨР**

| Улс | Санхүүгийн | Үйл ажиллагааны |
|---|---:|---:|
| Норвеги | 100.0 | 100.0 |
| Бразил | 100.0 | 100.0 |
| Казахстан | 100.0 | 100.0 |
| Орос | 95.9 | 92.7 |
| Чили | 75.0 | 100.0 |
| Азербайжан | 95.9 | 70.6 |
| АНУ | 66.8 | 88.9 |
| Колумб | 58.4 | 100.0 |
| Венесуэл | 62.5 | 88.9 |
| Йемен | 77.8 | 66.7 |
| Тринидад ба Тобаго | 54.3 | 85.2 |
| Мексик | 37.5 | 100.0 |
| Ирак | 62.5 | 77.8 |
| Либери | 71.0 | 66.7 |
| Зүүн Тимор | 77.8 | 51.9 |
| Малайз | 55.6 | 74.1 |
| Эквадор | 50.0 | 77.8 |
| Перу | 33.0 | 88.9 |
| Иран | 50.0 | 66.7 |
| Болив | 45.9 | 70.3 |
| Камерун | 33.0 | 77.8 |
| Индонез | 26.0 | 85.2 |
| Габон | 41.5 | 66.7 |

| | | |
|---|---|---|
| Ботсван | 37.5 | 66.7 |
| Нигери | 37.5 | 66.7 |
| Ангол | 29.1 | 70.4 |
| Хятад | 44.4 | 55.6 |
| Өмнөд Африк | 57.1 | 44.3 |
| Замби | 33.4 | 55.6 |
| Монгол | 57.0 | 33.4 |
| Сьерра Леоне | 41.6 | 40.8 |
| Папуа-Шинэ Гвиней | 33.3 | 48.1 |
| Гана | 38.8 | 33.3 |
| Саудын Араб | 0.0 | 66.7 |
| Танзани | 0.0 | 59.3 |
| Кувейт | 18.5 | 44.3 |
| Судан | 0.0 | 55.6 |
| Алжир | 16.5 | 33.1 |
| Туркменистан | 0.0 | 44.6 |
| Экваторын Гвиней | 0.0 | 29.6 |
| БНАКУ | 0.0 | 25.8 |
| **Дундаж** | **46.7** | **67.7** |

Тайлангийн мэдээлэл, түүний дотор улс орнуудын онцлогтой баримт бичгүүд, мэдээллийг үзэхийг хүсвэл www.revenuewatch.org/rwindex хаягаар хандана уу.

Төв банкууд эрдэс баялгийн экспортын үнийн дүн, салбарын үйл ажиллагаа, үнэтэй холбоотой мэдээлэл гаргах нь түгээмэл байдаг. Хэдий эдгээр сэдэв орлогын ил тод байдалд чухал ач холбогдолтой боловч хамгийн чухал нь биш. Олборлох үйлдвэрлэлээс орж байгаа орлогыг удирдахад Сангийн яамдын үүрэг илүү холбогдолтой байдаг бөгөөд тэд гол төлөв мэдээллээр хангах ажлыг хариуцдаг болохыг энэ судалгаа харуулж байна. Түүнээс гадна тэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас хүлээж авсан төлбөрийн тухай мэдээллийг тайлагнах хуваарь, давтамж, иж бүрэн байдлыг сайжруулах боломжтой. Үүний хажуугаар төрийн өмчийн компаниуд, олборлох салбарын яамд, зохицуулагч агентлагууд харьцангуй тогтмол бус, чанар муутай мэдээлэл гаргаж нийтэлдэг байна.  Эдгээр байгууллагуудад нийтлэг ажиглагддаг зүйл бол тэд мэдээ тайлангаа байнгын тогтмол хуваарьгүй, нилээд хугацаа алдаж нийтлэх нь олонтаа байдаг. Өөрөөр хэлбэл, олборлох үйлдвэрлэлийн салбартай шууд холбогдолтой  эдгээр байгууллага хамгийн муу тайлагналын практиктай байдаг байна.

### 4.3 Институцийн орчин

Энэ төрлийн мэдээлэл нь төрөөс газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт зориулсан нарийвчилсан хууль тогтоомж гаргаж нийтэлж байгаа эсэхтэй холбоотой. Хэдийгээр олборлох үйлдвэрлэлийн сайн засаглалд чухал ач холбогдолтой тодорхой дүрэм журам, урьдчилан таамаглаж болохуйц эрх зүйн хүрээ байдаг боловч аль нэг улсын хууль тогтоомж практик дээр яаж хэрэгжиж байгааг уг судалгаагаар шалгаагүй болно. Энэ бол цаашид судлах, ялангуяа орон нутгийн түвшинд ажиллаж байгаа иргэний нийгмийнхний судлавал зохих чухал чиглэл юм. Энэхүү индексийн зорилго талаас энэ хэсэгт өндөр оноо авна гэдэг нь улс орнууд бодит байдлаасаа илүү эрмэлзэлтэй байгааг илэрхийлж болно.

Орлогын Ажиглагч Индексийн доод хэсэгт байгаа олон орон энэ чиглэлд маш өндөр оноо авсан байгаа. Энэ нь дан ганц хууль тогтоомж өөрөө бодит хэрэгжилт, хууль сахиулалтын төгс үзүүлэлт биш гэдгийг уншигчдад сануулах ёстой. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын менежментийн дүрмүүд нь гэрээ хэлэлцээр, санхүүгийн болон үйл ажиллагааны тоо баримтыг ил болгох үндэс тэр бүр болдоггүй.

### 4.4 Газрын тос, байгалийн хий, уул уурхайн төрийн өмчит компаниуд

Энэхүү тайланд хамрагдсан нефть бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 30 улсын 28-д нь, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч есөн улсын долоод нь төрийн өмчит компаниуд ажиллаж байна. Гагцхүү АНУ л газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн хайгуул, ашиглалттай холбоотой бизнесийн компаниудад хувь эзэмших сонирхолгүй байхад Габон Улс ГТҮК байгуулах сонирхолтой байгаагаа албан ёсоор зарлаад байна[29]. Бусад цөөн хэдэн улс энэ хэсэгт огт хариулаагүй байгаа нь бид тэдний уул уурхайн салбарын тодорхой нэг чиглэлд гол анхаарлаа төвлөрүүлсэнтэй холбоотой болович тэдгээр улсын засгийн газар ашигт малтмал үйлдвэрлэгч компаниуддаа хувь эзэмшдэг нь тодорхой юм[30].

## Төрийн өмчит компани (ТӨК)

ТӨК-иуд нь өмчлөлийн бүтэц дэх төрийн оролцооны болон олон улсын хөрөнгийн биржийн жагсаалтад орсон түвшингээрээ харилцан адилгүй байдаг. Газрын тос, байгалийн хийн хувьд зөвхөн Бразил, Хятад, Колумб, Норвеги, Орос улсууд л хувийн хэсэгчилсэн өмчлөл бүхий үндэсний компаниудтай. Түүнчлэн Норвегийн СтатойлХидро, Бразилын Петробрас, Колумбийн Экопетрол, Оросын Газпром, Роснефть компаниуд л олон улсын томоохон хөрөнгийн биржүүдийн (Нью Йорк, Лондонгийн) жагсаалтад орсон ТӨК-иуд юм. Зарим улс компаниудынхаа тодорхой нэг хэсгийг ийм жагсаалтад оруулдаг. Тухайлбал, Хятад Улс толгой компаниа бус зөвхөн охин компаниудаа бүртгүүлдэг бол Казахстан ч бас үүнтэй төстэй нөхцөл байдалд байна.

Малайз Улс үйлдвэрлэлийн дээд хэсгийн салбараа, эсхүл холдинг компаниудаа бус, харин харъяа охин компаниудаа бүртгүүлээд байна. Цаашилбал, Мексикийн ТӨК гэх мэт төрийн өмчит тодорхой компаниуд бизнесийн практикуудаа сайжруулах, хөрөнгийн биржид бүртгүүлэлгүйгээр олон улсын үнэт цаасны зах зээлд өрийн бонд гаргаж борлуулахыг оролдоод байна. Уул уурхайн салбарын хувьд ерөнхийдөө тухайн улсын засгийн газар ТӨК-иудаа бүрэн өмчилдөг бол Ботсван, БНАКУ, Замби улсууд л уул уурхайн үндэсний компаниудаа хувийн өмчид нээлттэй болгосон байна. Түүнчлэн Замбийн үндэсний уул уурхайн компани одоогоор олон улсын томоохон биржид (Лондон, Парисын) бүртгэлтэй цорын ганц төрийн өмчит компани болж байгаа юм шиг байна.

Нийтдээ 14 улсын ТӨК тайлан тэнцэл, ашиг, алдагдлын гэх мэт үйл ажиллагааны тайлангаа бүрэн нийтэлсэн, хоёр нь орлого, татвар, цэвэр ашиг зэрэг тоо баримтын тайлангаа нийтэлсэн, найм нь үйл ажиллагааны мэдээллээ нарийвчилсан задаргаагүйгээр нийтэлсэн байна. 14 улсын ТӨК аудитын тайлангуудаа нийтэлжээ. Мөн 22 улсын засгийн газар хамтарсан үйлдвэр, эсхүл хувийн компаниуд дахь хувь эзэмшлийн оролцооны мэдээллээ нийтэлсэн байна. Тухайлбал, Бразил, Колумб, Норвеги улсууд бүгд нийтэд арилжаалагддаг газрын тосны компанитай байхад Чили, Казахстан, Мексик, Оросын компаниуд хөрөнгө оруулагчдын тайлан гаргадаг байна. Нэг тохиолдол буюу Эквадорын ГТҮК л гэрээлэлт, худалдан авалт, зарлага гэх мэтээ өргөнөөр тайлагнахыг шаарддаг мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд захирагддаг байна.

Энэ ангиллын нэг гол санаа тавих асуудал бол хагас төсвийн шинжтэй үйл ажиллагаагаа ил болгох явдал юм. Газрын тосны үндэсний компаниуд нь  орлогоо улс, нийгмийн чанартай төслүүдэд хэрхэн зарцуулж байгаа тухай зарим тоо баримт нийтэлдэг улс дөнгөж 10-хан байгааг тус индекс тогтоосон байна.

Улс орнууд төрийн өмчит компаниудаа ямар нэг хариуцлага тооцохгүй төслүүдэд ашиглаж, хууль тогтоогчоор хэлэлцүүлэн батлуулах ажиллагаанаас гадуур байлган, улмаар хөрөнгө шамшигдуулах эрсдэлтэй болгож байгаа нь ил тод бус байдлыг бий болгож байна.  Венесуэлийн PDVSA бол ийм ТӨК-ний нэг жишээ бөгөөд эдний мэдээлэлд өмнө нь олон улсын болон үндэсний мэргэжилтнүүд эргэлзэж байсан юм[31]. Бусад жишээ нь, Казахстаны КазмунайГаз компани шиг үйл ажиллагаагаа хэсэгчлэн хөрөнгийн биржид бүртгүүлсэн, түүндээ хайгуул, үйлдвэрлэлийн хэсгээ оруулаагүй байж болох компаниудаас үүдэлтэй байдаг. Ийм тохиолдолд илээр тайлагнаж байгаа мэдээлэл нь засгийн газрын өмчлөл, хувь эзэмшлийн хүрээг бүрэн илэрхийлэхгүй байж болох юм.

*Газрын тосны үндэсний компаниуд нь  орлогоо олон нийтийн болон, нийгмийн чанартай төслүүдэд хэрхэн зарцуулж байгаа тухай зарим тоо баримтаа нийтэлдэг улс дөнгөж 10-хан байгааг тус индекс тогтоосон байна.*

## 4.5 Байгалийн баялгийн сан (ББС)

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн гэнэтийн өсөлт, бараа, түүхий эдийн үнийн огцом өсөлтөөс гэнэт баяжсан засгийн газруудын сонгодог санхүүгийн хэрэгсэл болох Тусгаар баялгийн сангууд (ТБС) ихээхэн анхаарал татаж байна. ББС-ууд бол ТБС-ийн дэд ангилал бөгөөд Орлогын Ажиглагч Индекс нь эдгээр сангуудыг газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын орлогыг тусгайлан хуримтлуулахад зориулсан гэж үзэж байна. Энэхүү индексээр олж тогтоосон ББС-уудын зориулалт маш олон янз байдаг байна. Үүнд ирээдүй хойч үедээ зориулсан хуримтлал, тогтворжуулалтын сан, хөрөнгө оруулалтын корпорациуд  болон олборлолтын орлогыг төсвийн санхүүжилтээс эхлээд хөгжлийн төслүүд хүртэл олон янзын зориулалтаар шилжүүлэхэд зориулсан эскроу данс шиг үүрэг гүйцэтгэх зохицуулалтууд ордог. Сан бүрийн удирдаж байгаа хөрөнгийн хэмжээ ч харилцан адилгүй байна. Эдгээрийн зарим жишээнд Иран ба Мексикийн Газрын тосны тогтворжуулалтын сан, Кувейтын Хөрөнгө оруулалтын корпораци, Норвегийн Тэтгэврийн нэгдсэн сан, Зүүн Тиморын Нефтийн сан,  бүр АНУ-ын Газар, усны нөөцийн сан (LWCF)-г ч хэлж болно[32]. Ерөнхийдөө индекст хамрагдсан орнуудаас 29 нь ямар нэг хэлбэрийн байгалийн баялгийн сантай байна.

Индекст хамрагдсан 15 сан өөрийн хөрөнгө, гүйлгээний мэдээллээ нийтэлж байна. Жишээлбэл, Зүүн Тиморын Нефтийн сан жилийн эцсийн аудитын тайлан, улирлын тайлангуудаа гаргасны дотор орон нутгийн хэлээр (Тетум) гаргасан хувилбар оржээ. 10 тохиолдолд тухайн санг хариуцсан эрх бүхий байгууллага нь жилд аудитын тайлангаа нэгээс доошгүй удаа нийтэлсэн байна. Энэ хэсгийн судалгааны үр дүн нь улс орнууд дээрх сангуудынхаа үйл ажиллагааны дүрэм төдийгүй хөрөнгө, ажил гүйлгээнийхээ тухай аудитлагдсан мэдээлэл бүхий тогтмол тайлангууд нийтэлж байгаа эсэхийг харуулах төдий байна. Нөөц баялаг ихтэй орны засгийн газрууд газрын тос, байгалийн хий, уул уурхайн орлогоо хэрхэн удирдаж байгаа тухай илүү дэлгэрэнгүй дүр зургийг сонирхсон уншигчид ТБС-ийн засаглалтай (Сантиагогийн зарчим ч гэдэг) холбоотой Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд ба практикууд (GAPP), эсхүл Олон улсын эдийн засгийн Петерсоны институтын Тусгаар баялгийн сангуудын индекс гэх мэт илүү нарийвчилсан судалгааг үзэх хэрэгтэй[33].

## 4.6 Орон нутгийн шилжүүлэг

Энэ хэсэгт газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн орлогыг төв буюу холбооны засгийн газар болон бүсийн буюу орон нутгийн захиргааны хооронд хэрхэн хувааж байгаа талаар засгийн газруудын нийтэлсэн мэдээллийг үнэлдэг[34].

Орлогын Ажиглагч Индексээс үзэхэд орон нутгийн шилжүүлэг хийдэг 29 улсын дөнгөж 13 нь л орон нутгийн захиргаанд шилжүүлсэн нөөц баялгийн орлогынхоо мэдээллийг нийтэлж байна. Орон нутгийн захиргаад олборлох үйлдвэрлэлээс хүлээж авсан орлогоо ил болгож байгаа эсэх нь бас чухал ач холбогдолтой. Хэдийгээр мэдээлэл хомс байсан ч ядаж нэг орон нутгийн захиргаа нь төв засгийн газраасаа хүлээж авсан орлогынхоо талаар зарим мэдээлэл нийтэлсэн 10 улс байгааг олж тогтоосон. Гана, Индонез, Нигери, Перу улсуудын орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа ОАИ-ийн төслүүд бол орон нутгийн захиргаад энэ талаар хэрхэн санаачлагатай ажиллаж эхэлж байгаагийн жишээ юм.

Гэхдээ Орлогын хязгаарлагдмал ил тод байдлын бүлэгт багтсан бараг бүх улсын засгийн газар нь орон нутгийн захиргаадтайгаа орлогоо хэрхэн хувааж байгаа талаар мэдээллээр хангадаггүй (төвлөрсөн засгийн газартай улсуудыг ч тооцохгүйгээр) байна. Орон нутгийн шилжүүлгийн тухай мэдээлэл хомс байгаа нь орон нутгийн засгийн газрууд байгаа нөөц баялгаа зөв тооцоолж, үр дүнтэй төлөвлөлт хийхэд хүндрэл үүсгэдэг.

*Тухайн улсын ОҮИТБС-д оролцох оролцоо, статусыг үнэлэх нь Орлогын ил тод байдлын индекст орсон цорын ганц үзүүлэлт байв.*

## 4.7 ОҮИТБС

ОҮИТБС-ын гишүүн орнууд Орлогын Ажиглагч Индексийн бүхий л бүлэгт орсон байв. Тэдний дөрөв нь Орлогын иж бүрэн ил тод байдлын бүлэгт, 10 нь хэсэгчилсэн ил тод байдлын бүлэгт, дөрөв нь уг индексийн хамгийн доод хэсэгт (Орлогын хязгаарлагдмал ил тод байдал) орсон байна.

Тухайн улсын ОҮИТБС-д оролцох оролцоо, статусыг үнэлэх нь Орлогын ил тод байдлын индекст орсон цорын ганц үзүүлэлт байв. Гэхдээ уг индексийн судалгаанд ОҮИТБС-ын бусад шалгуурын хэрэгжилтийг ч бас харгалзан үзсэн. Үүнд аливаа улс ОҮИТБС-д нэр дэвшигч улс эсэх, ОҮИТБС-ын тайлангаа гаргасан эсэх, ийм тайландаа аудитлагдсан төлбөрүүд, төрийн өмчит компаниудын мэдээллийг оруулсан эсэх, тайланг хараат бус байгууллага тулгаж нэгтгэсэн эсэхийг харгалзсан. Индексийн судалгаа хийж байх үед (2009 оны 11 сараас 2010 оны 4 сар хүртэл) ОҮИТБС-ын баталгаажуулалт ид явагдаж байсан бөгөөд тодорхой улс орнууд (Эквадорын Гвиней гэх мэт) ОҮИТБС-ын гишүүний статусаа алдаж, зарим нь (Ирак) нэр дэвшигч болсон байна. Хэдийгээр Орлогын Ажиглагч Индекс нь эдгээр улс орнууд ОҮИТБС-ын шалгуурыг хангаж байгаа эсэхийг хэмждэггүй боловч энэ тайланд хэрэгжилтийн оноог нь гаргаж Хүснэгт 5-д үзүүлэв. Гэхдээ энэ бол ОҮИТБС-ын үйл явцын үнэлгээ ч биш, эдгээр орнуудын баталгаажуулалтыг орлох үзүүлэлт ч биш юм.

ХҮСНЭГТ 5

**ОҮИТБС-ЫН ОРНУУДЫН ОРЛОГЫН АЖИГЛАГч ИНДЕКСИЙН ОНОО**

| Улс | ОҮИТБС-ын шалгуурын хэрэгжилт | Орлогын Ажиглагч Индекс |
|---|---|---|
| Норвеги | 86.8 | 96.4 |
| Казахстан | 66.6 | 77.5 |
| Перу | 80.2 | 76.8 |
| Азербайжан | 86.8 | 75.1 |
| Зүүн Тимор | 91.8 | 70.5 |
| Ирак | 16.5 | 63.8 |
| Йемен | 16.8 | 60.5 |
| Либери | 83.3 | 60.5 |
| Нигери | 86.8 | 46.5 |
| Габон | 53.4 | 41.8 |
| Камерун | 60.0 | 41.8 |
| Замби | 16.5 | 41.2 |
| Сьерра Леоне | 83.3 | 38.2 |
| Монгол | 80.2 | 38.2 |
| Гана | 91.8 | 32.3 |
| Танзани | 16.5 | 27.8 |
| БНАКУ | 66.6 | 22.5 |
| Эквадорын Гвиней | 66.6 | 11.6 |
| **Дундаж** | **70.3** | **50.6** |

## Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)

Орлогын Ажиглагч Индекст зориулан цуглуулсан мэдээллээс бид зарим улс ил тод байдлын шалгууртай холбоотой ОҮИТБС-ын биелэлт сайтай боловч орлогын ил тод байдлын сорилтод унаж байгааг тогтоолоо (Хүснэгт 5-ыг үзнэ үү). БНАКУ, Монгол, Нигери зэрэг орнууд ОҮИТБС-ын шалгууруудыг харьцангуй өндөр түвшинд хангасан хэдий ч мэдээлэл авах боломжоо сайжруулах шаардлагатай байна. ОҮИТБС-ын хэрэгжилт, орлогын ил тод байдлын онооны их зөрүү нь бодит байдал дээр эдгээр орнуудын засгийн газрын өгч чадахгүй байгаа чухал мэдээллийг ОҮИТБС хангаж байгааг харуулж байна. Энэ нь ОҮИТБС эдгээр орны хувьд засгийн газрыг нь олон нийтийн хяналт шалгалтад нээж өгч байгаа цорын ганц чухал санаачилга болохын зэрэгцээ цаашид хэрэгжүүлэлтийн хүрээгээ тэлж мэдээллийн нээлттэй байдлын түвшнээ дээшлүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна. Ийм орнууд ОҮИТБС-аар дамжуулан ил тод байдлаа бэхжүүлсэн хэдий ч засгийн газар нь иргэддээ иж бүрэн тайланг тогтмол, цаг алдалгүй хүргэх хэрэгцээ байсаар байна.

Үүний нэг жишээ болох Нигери Улс 1999-2004, 2005 оны төсвийн жилийг хамарсан ОҮИТБС-ын хоёр тайлан гаргаад байна. Эдгээр нь Нигерийн салбар хариуцсан олон яамдын хувьд мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож байгаа ганц баримт бичиг юм. Цаашилбал, 2005 оноос хойш ийм иж бүрэн мэдээллээр хангасан эх сурвалж гараагүй ба ОҮИТБС-ын тайлангууд маш их хугацаа алдаж гарч байгаа нь санаа зовоосон асуудал болоод байна. Камерунд ч, Ганад ч байдал ижил гэж хэлж болно. Энэ нь засгийн газрууд цагтаа тайлагнах чадвараа сайжруулж, мэдээллийг ил болгож тайлагнах ажиллагааг нэг удаагийн бус, байнгын тогтвортой үйл ажиллагаа болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Орлогын ерөнхий ил тод байдал талаас ОҮИТБС-ын ил тод байдлын шалгуурыг хэрэгжүүлэх тал дээр Камерун, Габон зэрэг улсууд харьцангуй дээр ажиллаж байна.

Гэсэн хэдий ч Орлогын Ажиглагч Индексийн судалгаагаар эдгээр орон ОҮИТБС-ын хүрээндээ ч сайжруулах зүйл байгаа ба энэ хоёр улсын ОҮИТБС-ын тайлан газрын тос, байгалийн хийн салбарын ил тод, хариуцлагатай байдлын түвшинг жинхэнэ ёсоор дээшлүүлэхэд хангалтгүй, өнгөц байна гэсэн дотоодын иргэний нийгмийнхний шүүмжлэлийг тусгах хэрэгтэйг тогтоосон[35]. ОҮИТБС-ын тайлангаа нийтэлснийг эс тооцвол дээрх улс хоёулаа Орлогын Ажиглагч Индексийн сүүл хавьд явж байна. Өөр чухал гэж болох нэг жишээ бол Либери, Сьерра Леоне хоёр бөгөөд тэд ОҮИТБС-ыг сайн хэрэгжүүлж байгааг эс тооцвол орлогын ил тод байдлын хувьд дундаж үзүүлэлттэй байгаа юм. Либерийн хувьд ОҮИТБС-ын тайлангаа гайхалтай иж бүрэн хийсэн нь энэ санаачилгын тэргүүн туршлагын нэг болж байна.

Казахстан, Норвеги улсууд ОҮИТБС-ын ил тод байдлын шалгуурын хэрэгжилт, орлогын ил тод байдлын хувьд ижил төстэй түвшинд байна. Гэвч хэсгийн оноог нь нарийвчилж үзвэл сайжруулах орон зай бас л байна. Жишээлбэл, эдгээр орон гэрээний болон тусгай зөвшөөрлийн ил тод байдлын түвшнээ дээшлүүлэх (хоёулаа), орлогын тайлангийн задаргаа, нөөц баялагт хүрэх боломжоо сайжруулах (Казахстаны хувьд) боломжтой.

Тайланг бичиж байх энэ мөчид Танзани, Йемен, Замби улсууд ОҮИТБС-ын тайлангаа хараахан нийтлээгүй байв. Тэд энэ санаачилгад ахиц дэвшил гаргах замаар орлогын ил тод байдлын түвшнээ сайжруулах ёстой.

Эцэст нь, ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын хувьд уг ажиллагаа нь шинэтгэлийн төгсгөл биш, эхлэл байх ёстой гэдгийг уг индексийн үр дүн нотлон харуулж байна. Мэдээллийг тогтмол, байнга, цаг алдалгүй, иж бүрэн ил болгож нийтлэхэд тогтсон стандарт байх ёстой бөгөөд энэхүү индекст тааруухан оноо авах шалтаг нь ОҮИТБС байх ёсгүй.

# Орлогын Ажиглагч Индекс

Байгалийн баялгийн засаглалын долоон гол ангилал дахь мэдээллийн нээлттэй байдалд тулгуурлан уг индексийн зэрэглэлийг тогтоодог. Тайлангийн тоо баримтууд, улс орны онцлогтой мэдээллийг үзэх буюу татаж авахыг хүсвэл www.revenuewatch.org/rwindex хаягаар хандана уу.






## Орлого бүрдүүлэлт

Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас засгийн газрын хүлээж авсан төлбөрүүд, бусад орлогын тухай мэдээлэл



## Нөөц баялагт хүрэх боломж

Аливаа улсын байгалийн баялгийн нөөц, олборлох салбарын бүтэц бүрэлдэхүүний тухай мэдээлэл



## Институцийн орчин

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулалт, захиргааны журмуудын тухай мэдээлэл



## Төрийн өмчит компани

Үндэсний засгийн газрын мэдэлд ажилладаг газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, засаглал, санхүүгийн байдлын тухай мэдээлэл






## Байгалийн баялгийн сан

Байгалийн баялгийн орлого хуримтлуулахад зориулсан үндэсний сангуудын бүтэц, зохицуулалт, санхүүгийн байдлын тухай мэдээлэл



## Орон нутгийн шилжүүлэг

Холбооны, эсхүл төв засгийн газраас орон нутгийн засгийн газар, нутгийн ард иргэдэд байгалийн баялгийн орлогыг шилжүүлсэн тухай мэдээлэл




## ОҮИТБС

Тайлагнал, салбар хоорондын хамтын ажиллагааны сайн дурын стандарт болох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага дахь улс орнуудын байр суурь ба ахиц дэвшил

# 5 Эрх зүй, зохицуулалтын хүрээ

Эрх зүй, зохицуулалтын хүрээнд тус төслөөс газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын удирдлагын хууль журмуудыг олж тогтоосон. Энэ судалгаа эрх зүй, зохицуулалтын хүрээний бодит хэрэгжилтийг улс орны түвшинд шалгаж үздэггүй. Гэхдээ судалгааны асуултууд нь гурван ангилалд (нөөц баялагт хүрэх боломж, институцийн орчин, газрын тос, байгалийн хий, уул уурхайн төрийн өмчит компаниуд) хамаарах чухал сэдэвчилсэн мэдээллээр хангаж чаддаг. Эрх зүй, зохицуулалтын хүрээний асуултууд нь улс орнууд нөөц баялаг ашиглах эрх олгохдоо баримталдаг тусгай зөвшөөрлийн талаар болон олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас тусдаа тусгай зөвшөөрөл хариуцсан агентлаг байгаа эсэх, нөөц баялаг ашиглах эрхийн гэрээ хэлэлцээр хийж байгаа эрх бүхий этгээдүүдэд ямар хяналт шалгалт тавьж байгааг асуудаг.

Газрын тос, байгалийн хийн хайгуул, үйлдвэрлэлийн янз бүрийн талыг тойрсон өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргыг олон орон хэрэглэдэг бөгөөд тусгай зөвшөөрөл олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээнээс эхлээд үйлчилгээний гэрээ байгуулах түншүүдээ сонгох, эсхүл бараа, үйлчилгээ худалдан авалтын хамгийн сайн тохиролцоонд хүрэх хүртэл олон хэлбэртэй байдаг. Энэ олон янзын арга хэлбэрийг Алжир, Ангол, Мексик улсуудын жишээ харуулдаг. Болив, Камерун, Эквадор, Венесуэл гэх мэт бусад орны засгийн газрууд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөц ашиглах ялгавартай дүрмүүд бүхий нарийн түвэгтэй салбарууд бий болгосон байдаг нь дур зоргоороо шийдвэр гаргах, ашиг сонирхлын зөрчил гарах, ил тод бус дүрэм журамтай байх боломжийг бүрдүүлдэг. Эцэст нь, Эквадорын Гвиней, Туркменистан зэрэг улсад ямар компанид нөөц баялагт хүрэх эрх олгох тухай шийдвэрийг гүйцэтгэх засаглалын тэргүүний мэдэлд үлдээж иржээ.

Лиценз буюу тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дур зоргын эрх мэдэлд хяналт шалгалт хийх байдал улс орон бүрт харилцан адилгүй байна. Энэхүү тайланд орсон улс орнуудын бараг тал хувь нь гол зарчмуудаас, эсхүл дуудлага худалдааны дараах хэлэлцээрүүдээс хазайхыг хязгаарласан, аль эсвэл төсөв санхүү, зохицуулалтын зарчмуудад нөлөө үзүүлж чадахуйц өөр нэг хараат бус эрх бүхий этгээдээр батлуулахыг шаардсан хууль тогтоомжтой байна.

Мөн газрын тос, байгалийн хий, уул уурхайн гэрээнүүдээ парламентаар соёрхон батлуулахыг шаарддаг есөн улс байна. Гэхдээ бодит амьдрал дээр эдгээр дүрэм, журам нь орлогын ил тод байдлыг сайжруулах баталгаа болох албагүй байдгийг Болив, Гана, Иран, Кувейт, Монгол, Өмнөд Африк, Венесуэл, Йемен улсуудын жишээ нотлон харуулав. Парламентын ийм хяналтыг эс тооцвол, эдгээр улсад нөөц баялагт хүрэх боломжийг зохицуулах дүрэм, журмын тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгдөггүй. Энэ бол цаасан дээр болон бодит амьдрал дээрх зохицуулалтын хүрээг ялгах өөр нэг жишээ юм. Цаашид эдгээр хууль тогтоомжийг бодит байдал дээр яаж хэрэгжүүлж байгааг болон мэдээллийн чанар, хүртээмжийг судлан шалгаж болох юм.

## Тусгай зөвшөөрөл олгох журмууд

Орлогын Ажиглагч Индекст хамрагдсан орнуудад засгийн газраас байгалийн баялаг ашиглах тусгай зөвшөөрөл олгож байгаа арга зам нь олон янз байна. Тэдний ихэнх нь тусгай зөвшөөрлийн журам ашиглах хандлагатай байдаг бол Кувейт, Мексик, Саудын Араб зэрэг бусад орон энэ аргад найддаггүй. Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн орлогоос хамгийн их хамааралтай зарим орон энэ салбарт орох монополь эрх бүхий үндэсний компаниар тусгай зөвшөөрөл олгох журмаа удирдуулдаг. Үүнд Ангол, Иран, Кувейт, Мексик, Саудын Араб, Судан, Туркменистан улсууд багтдаг. Бусад улсууд олборлох салбар хариуцсан яамдаараа уг үйл явцыг удирдуулдаг бөгөөд саяхан ийм жишээ Алжир, Венесуэлд гарсан[36]. Эцэст нь, Нигери Улс саяхан тусгай зөвшөөрөл олгох журмынхаа удирдлагыг зохицуулагч агентлагтаа хариуцуулсан байна.

Ялангуяа, Гана, Монгол, Өмнөд Африк улсууд эрх зүй, зохицуулалтын хүрээнийхээ талаар асар их мэдээлэл өгдөг боловч тэд Орлогын Ажиглагч Индексийг тэргүүлэгч орнуудын тоонд ордоггүй. Энэ байдлаас үзэхэд тусгай зөвшөөрлийн бие даасан агентлаг, үйл ажиллагааны компаниуд, тусгай зөвшөөрлийн өрсөлдөөнт ажиллагаа, дур зоргоор шийдвэрлэх эрх мэдлийн хязгаарлалт, уул уурхайн салбарын гэрээ хэлэлцээрүүдийг хууль тогтоох байгууллагаар батлуулах ажиллагаа зэрэг мэдээллийг олон нийтэд иж бүрэн тайлагнадаг хэлбэрт шилжүүлэх шаардлага хэвээр байгаа нь харагдаж байна.

Мөн олборлох үйлдвэрлэлийн удирдлагад гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийг салгаж хуваарилахтай холбоотой асуултуудыг эрх зүй, зохицуулалтын хүрээний судалгаанд оруулсан байгаа. Түүнчлэн, нөөц баялаг ашиглагч компаниудаас төлбөр хүлээн авч байгаа төрийн байгууллагуудын дотоод, гадаад хяналтын асуудлыг харгалзсан төдийгүй аудитын практикийн онцлогууд, парламентын ба иргэний нийгмийн хяналтын цар хүрээг авч үзсэн болно.

Бразил, Колумб, Норвеги улсууд төрийн янз бүрийн байгууллагуудын дунд үүрэг, эрх мэдлийг салган хуваарилах замаар тэргүүн туршлагын загвар болохуйц эрх зүй, зохицуулалтын сайн орчинг бүрдүүлсэн байдаг. Энэ загвараар бол төсвийн бодлого, татвар хураалтыг Сангийн сайдын эрхлэх асуудалд оруулж, олборлох үйлдвэрлэлийн бодлого боловсруулах, зохицуулах ажлыг бие даасан агентлагт, цэвэр арилжааны шинжтэй асуудлуудыг төрийн өмчийн компанидаа тус тус хариуцуулсан байна. Нүүрс устөрөгчийн хайгуул, олборлолтыг хянах бие даасан зохицуулах агентлагтай, харьцангуй хүчтэй татварын системтэй, нийтэд арилжаалагддаг төрийн мэдлийн компаниудтай байх нь эдгээр улсын олборлох үйлдвэрлэлийн тухай мэдээллийг олон эх сурвалжтай болгож, улмаар мэдээллийн ил тод тайлагналыг хүчтэй болгодог байна. Иймээс тэд эрх зүй, зохицуулалтын хүчтэй тогтолцооны жишээ болдог бөгөөд улмаар үр дүнтэй хэрэгжүүлвэл олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дээшлүүлж чаддаг.

## Улсын ГТҮК-ий бүтцийн Норвегийн загварыг экспортлоход тулгамддаг асуудлууд

Үүрэг хариуцлага, эрх мэдлийн албан ёсны хуваарилалтаар бол Норвегийн нефтийн салбар бодлого хариуцсан яам, хяналт шинжилгээ хариуцсан бие даасан зохицуулагч байгууллага, цэвэр арилжааны үйл ажиллагаа хариуцсан ГТҮК-д хуваагддаг бөгөөд энэ бүтцийг олон улсын тэргүүн туршлага гэж үзэх нь олонтаа байдаг. Норвегийн загвар амжилттай хэрэгжиж байгаа нь Бразил зэрэг улс эрчим хүчний салбартаа энэ чиглэлийн дагуу шинэтгэл хийх урам өгсөн юм.

Гэвч энэ загварыг Алжир, Нигери улсууд авч хэрэглэхийг оролдсон ч эсэргүүцэлтэй тулгарсны улмаас энэ шинэтгэл зогссон байна. Үүний хажуугаар, Ангол, Малайз улсууд ийм хуваарилалт хийлгүйгээр сайн ажиллагаатай газрын тосны салбар бий болгож чадаж байна.

Сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд, Норвегийн загвар олон газарт шилдэгт тооцогдож байхад институцийн чадавхи маш муутай, албан ёсны хяналт шалгалтын түүх багатай орнуудад хоёр дахь сайн арга нь илүү тохирохоор байна. Энэ арга нь дээрх гурван институцийг зэрэг бий болгож бэхжүүлэхийг оролдохын оронд олон нийтэд тайлагнах шаардлага, хяналтын зөвлөлүүдээр дамжуулан хариуцлагатай байдлыг бага багаар суулгаж өгөхийг эрмэлздэг байна[37]. Орлогын Ажиглагч Индексийн зүгээс төрийн өмчит ГТҮК-дын харилцаанд тохирох тэргүүн туршлага бол Норвегийн загвар гэж үздэг боловч түүний үр нөлөөг дэлхийн нийтийн хэмжээнд авч үзсэн шинэ судалгаануудыг эрж хайсаар байх болно.

Гэвч эрх мэдлийн албан ёсны хуваарилалт нь өөрөө хяналт шалгалтын үр дүнтэй тогтолцоог илэрхийлдэггүй. Эрх зүй, зохицуулалтын хүрээний тухай асуултуудаар цуглуулсан мэдээллээс үзэхэд, мэдээллийг ил болгож тайлагнах талаар хамгийн амжилттай ажиллаж буй зарим улс олборлох үйлдвэрлэлийн удирдлага дахь үүрэг хариуцлага, эрх мэдлийг тодорхой хуваарилсан институцийн орчинтой байдаг. Гэтэл БНАКУ, Эквадорын Гвиней, Гана зэрэг үүрэг хариуцлагын механизмуудаа тусд нь тогтоож өгсөн хуультай орнуудад Засгийн газар нь олборлох үйлдвэрлэлээсээ хэрхэн орлого бүрдүүлж байгаа тухай мэдээлэл хомс хэвээр байна.

Төрийн өмчийн компаниудын тухай асуултууд нь эдгээр компани олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн стандарт мөрдөж байгаа эсэх, ТӨК-ий бүх салбарыг хамарсан аудит хийгдэж байгаа эсэхтэй холбоотой байдаг. Ялангуяа, хөрөнгийн биржээр нийтэд арилжаалагддаг (буюу хэсэгчлэн бүртгэлтэй) төрийн өмчийн компаниуд эдгээр практикийг дагаж байгаа эсэхийг асуудаг. Энэ нь Орлогын иж бүрэн ил тод байдлын бүлэгт байгаа Бразил, Чили, Норвегийн компаниудын нөхцөл байдал юм. Харин олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн стандарт хэрэглэх, аудитын тайлангуудаа нийтлэх асуудал зөвхөн нийтэд арилжаалагддаг компаниудаар хязгаарлагддаггүй болохыг Малайз, Мексикийн 100 хувь төрийн өмчийн компаниуд харуулж байна.

Орлогын Ажиглагч Индексийн судалгааны явцад онцлон тэмдэглэсэн нэг зүйл бол нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг тогтооход бэрхшээлтэй байсан явдал юм. Бид энэ судалгаандаа төрийн өмчит компаниуд нэр хүнд бүхий бүртгэлийн компаниудаар аудит хийлгэсэн, аудитын тайландаа олон улсын санхүүгийн тайлангийн стандартууд, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудын аль нэгийг баримталсан эсэхээ дурдсан тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн стандарт ашигласанд тооцож байгаа. Энэ ойлголтын дагуу 19 орны компаниуд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн стандарт мөрдөж байгаа бол, бүртгэлийн

практикуудаа сайжруулах шаардлагатай төрийн өмчит компаниудтай 10 улс байна. Компаниуд нь аудитын тайлангаа ч нийтэлдэггүй Алжир, Экваторын Гвиней, Индонез, Ирак, Иран, Туркменистан, Йемен, Замби шиг зарим улсын хувьд энэ чиглэлээр тууштай арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай.

# 6 Бүс нутгийн үр дүн

**ОРЛОГЫН АЖИГЛАГЧ ИНДЕКСИЙН ҮР ДҮНГИЙН ДУНДАЖ, БҮС НУТГААР**




*Ойрхи дорнод, Хойд Америкийн бүс нутгаас ганц ч улс жагсаалтын дээд хэсэгт бичигдсэнгүй, бүс нутгийн дунджаараа сүүлээсээ хоёрт явж байна (40.9).*

Орлогын Ажиглагч Индексийн бүс нутгийн дундаж үзүүлэлт нь газар зүйн хувьд ихээхэн ялгааг харуулж байна. Энд хамгийн бага оноотой бүс нутаг нь Сахар орчмын Африк (дундаж оноо нь 38.6) байна. Энэ бүс нутгийн зарим улс ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх зэргээр сайн засаглалын хүчин чармайлт гаргаж байгааг эс тооцвол, дийлэнх улсад нь нөөц баялагт хүрэх боломжийн ил тод байдал муутай, орлогын ил тод байдлын мэдээлэл дутагдалтай байсан явдал ийнхүү бага оноо авахад хүргэжээ.

Ойрхи Дорнод, Хойд Америк (ОДХА)-ийн бүс нутгаас ганц ч улс жагсаалтын дээд хэсэгт бичигдсэнгүй, бүс нутгийн дунджаараа сүүлээсээ хоёрт (дундаж оноо нь 40.9) орсон байна. Ерөнхийдөө, ОДХА-н орнууд нөөц баялагт хүрэх боломжийн тухай мэдээлэлдээ тааруухан амжилт үзүүлж, Орлогын Ажиглагч Индексийн энэ хэсэгт нэг ч улс 50-иас дээш оноо аваагүй нь бодит байдал дээр энэ бүс нутаг дэлхийн нүүрс устөрөгчийн нөөцийн талаас илүү хувийг агуулдаг гэхэд цочирдмоор үр дүн юм. Мөн энэ бүс нутгийн улс орнууд дэлхийн газрын тосны гуравны нэгийг үйлдвэрлэдэг гэдгийг эс тооцвол орлого бүрдүүлэлтийн тухай мэдээлэл авах боломж муутай байна[38]. Ирак Улс орлогын ил тод байдлаар өндөр амжилт үзүүлж, ялангуяа Баялгийн тусгай сангийн чиглэлээр маш сайн ажиллаж байна. Энэ санг 2003 онд НҮБ-ын 1483 дугаар тогтоолоор Иракийн хөгжлийн сан болгож байгуулсан юм. Харин Алжир, Кувейт, Саудын Араб орлогын ил тод байдлын бүхий л ангиллын хүрээнд хамгийн доод хэсэгт бичигдэж байна.

Ази-Номхон далайн бүс нутгийн (дундаж оноо нь 50.1) хувьд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч улс бараг байхгүйг эс тооцвол, Зүүн Тимороос бусад бүх улс Орлогын хэсэгчилсэн ил тод байдлын хэсэгт эргэлдэж байна. Харин Төв Ази, Оросын бүс нутагт (дундаж оноо нь 63) Азербайжан, Казахстан, Орос улсууд дээд амжилт үзүүлж, Орлогын иж бүрэн ил тод байдлын бүлэгт багтжээ. Энэ нь нэг талаас төрийн байгууллагууд нь тогтмол тайлан гаргадаг, бас Казахстанд ОҮИТБС-ыг нэвтрүүлсэнтэй холбоотой. Туркменистан Улс орлогын ил тод байдлын бүхий л ангилалд тааруухан амжилт үзүүлсэн байна.

Латин Америкийн бүс нутгийн (дундаж оноо нь 72.6) бүх улс Орлогын Ажиглагч Индекст 50-иас дээш оноо авчээ. Тус бүс нутаг Орлогын Ажиглагч Индексийн дээд хэсэгт зонхилж байгаа ч ОҮИТБС-ын оролцоогоо сайжруулах боломжтой39. Энэ бүс нутгийн onooны доод хэсэгт Болив, Тринидад ба Тобаго, Венесуэл улсууд байгаагаас Венесуэл Улс нөөц баялагт хүрэх боломжийн тухай мэдээллийн болон баялгийн тусгай сангийн ил тод байдлын чиглэлээр тааруухан үнэлгээ авсан байна[40].

Эцэст, ЭЗХАХБ-ын гишүүн орнууд бүс нутгийн дунджийг тэргүүлж байна (дундаж оноо нь 82.9). Норвеги Улс уг индексийн бүх ангиллын оргилд буюу дээд хэсэг орчимд байгаа нь яагаад тус улсыг тэргүүн туршлагын жишээ болгож олонтаа ашигласны тайлбар болно. АНУ-ын хувьд зөвхөн Мексикийн булангийн холбооны нөөцийн менежментийг судалгаанд хамруулдаг. Хэдийгээр тус улс нөөц баялагт хүрэх боломжийн ил тод байдлаар өндөр оноо авсан боловч орлого бүрдүүлэлтийн ил тод байдлаар дундаж оноо авсны зэрэгцээ ОҮИТБС-ыг хэрэгжүүлээгүй байна. Харин уул уурхайн үйлдвэрлэгч орнууд дотроос орлогын ил тод байдлын хамгийн өндөр оноог Чили Улс авчээ.

# 7 Дүгнэлт, санал зөвлөмжүүд

Энэхүү тайланд хамрагдсан дийлэнх улс байгалийн баялгийн салбарын талаар хязгаарлагдмал мэдээллээр хангадаг болохыг Орлогын Ажиглагч Индекс харуулж байна. Иймхүү ил тод байдал дутагдах нь улсын хөрөнгийн удирдлагын асуудлаар иргэд засгийн газартайгаа тооцох хариуцлагыг сул болгодог.

Төр засаг иргэдээ төлөөлөн хөрсөн доорх баялгаа удирддаг. Нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газар зохицуулалтаараа дамжуулж ашигт малтмалын хайгуул, олборлолтод шууд бус заавар удирдамж өгөх юмуу, төрийн өмчит компаниудаараа дамжуулж шууд хяналт тавьдаг. Иймээс тэд улсынхаа үйлдвэрлэн гаргаж байгаа бүтээгдэхүүний иж бүрэн тооцоо, гэрээний нөхцөл, болзол, хүлээн авч байгаа төлбөрүүдийнхээ талаар нийтэлж, үйл ажиллагааг нь үнэлэх боломжийг иргэддээ олгох ёстой.

*Нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газар зохицуулалтаараа дамжуулж ашигт малтмалын хайгуул, олборлолтод шууд бус заавар, удирдамж өгөх юмуу, төрийн өмчит компаниудаараа дамжуулж шууд хяналт тавьдаг байна.*

Энэхүү индекс нь засгийн газраас ил тод байдлыг дээшлүүлэх хүчин чармайлт гаргах шаардлагатай байгаа чиглэлүүдийн, түүний дотор томоохон хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн мэдээллээр олон нийтийг хангах, газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбараас засгийн газрын хүлээн авч байгаа төлбөрүүдийг нийтэд ил болгох зэрэг чиглэлийн иж бүрэн дүр зургаар хангадаг. Зарим улс мэдээлэл авах боломжийг дээшлүүлэх талаар ихээхэн ахиц дэвшил гаргасан байдаг ч сайжруулах бодитой орон зай байгааг бид олж харсаар байна. Олон засгийн газар газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйл ажиллагааны төлбөр, орлогыг ил болгох албан ёсны үүрэг амлалт авсныг эс тооцвол олон нийтэд өгөх ёстой чухал мэдээлэл нь дутуу хэвээр байна.

Энэ индексийн үр дүнгээс үзэхэд аюулгүй байдал, эсхүл гэрээний нууцлал нэрээр нөөц баялгийн мэдээллийг нууцалдаг байдлаа зөвтгөх нь ихээхэн үндэслэлгүй болох нь харагдаж байна. Ихэнх орны засгийн газар бусад засгийн газрын ямар нэг харагдахуйц сөрөг үр дагаваргүй байхад нууцлахыг оролдоод байгаа сэдвүүдээр мэдээлэл гаргаж өгөхөд бэлэн байгаа тухай асар их нотлох баримтыг энэ тайлан гаргаж өгч байна.

Олборлох үйлдвэрлэлээс гарч болох боломжит сөрөг үр дагавруудыг бууруулахад ил тод байдал дангаараа хангалтгүй. Гэхдээ баттай, батлагдахуйц мэдээлэл нэмэгдэхийн хэрээр нөөц баялгийн менежментийн чанар сайжирдаг болох нь нотлогдож байна.

## Бодлогын зөвлөмжүүд

### Засгийн газруудад:

1. **Байгалийн баялаг ихтэй бүх улс орнууд гэрээний ил тод байдлаа бодитойгоор нэмэгдүүлэх хэрэгтэй байна.** Гэрээнүүд, хөрөнгө оруулалтын гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, олборлох үйлдвэрлэлийн салбарын төсөв санхүүгийн дэглэмийг олон нийтийн хяналтад нээлттэй болгох ёстой. Нөөц баялаг ашиглах тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах ажиллагаанд мэдээллийг ил тод болгох нь хамгийн их хязгаарлагдмал байдгийг энэ индекс харууллаа. Судалгаанд хамрагдсан цөөхөн улс л гэрээнүүдээ ил болгож нийтэлсэн ч орлого бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, түүнийг

дагаж мөрдөлтөд хяналт тавих боломжгүй болгож байна. Тэр ч байтугай, гэрээний мэдээллээ эрдэс баялгаас бусад яамдтайгаа ч хуваалцдаггүй олон орон байна. Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэлийн төсөв санхүүгийн нөхцлүүдийг заавал нийтэлж, болж өгвөл хуулиар баталгаажуулах хэрэгтэй. Гэрээ, түрээс, тусгай зөвшөөрлийн нөхцлүүдийг нийтлэх ажиллагааг ОҮИТБС-ын ил тод байдлын маягтуудад оруулж өгөх хэрэгтэй.

2. **Олборлох үйлдвэрлэлийн компаниудын хувьд олон улсын санхүүгийн гол чухал зангилаа нь болдог улс орнууд тус салбарт ил тод байдлыг хөхиүлэн дэмжих чиглэлд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой.** АНУ бол дэлхийн хамгийн том эдийн засагтай орон, байгалийн баялгийн үндсэн хэрэглэгчдийн нэг, дэлхий дээрх газрын тос, уул уурхайн хамгийн чухал олон компаний эзэн орон. Саяхан АНУ-ын Засгийн газар олборлолтын компаниудаас газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслүүдийнхээ санхүүгийн дэлгэрэнгүй мэдээллийг ил болгож тайлагнахыг шаардсан санхүүгийн шинэтгэлийн хууль гаргаж батлах замаар ил тод байдал, сайн засаглалыг хөхиүлэн дэмжихэд манлайлж байгаагаа нотлон харуулсан[41]. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн зах зээлд томоохон тоглогчид болох бусад аж үйлдвэржсэн орнууд ч гэсэн үүнтэй төстэй тайлагнах шаардлага бий болгох хэрэгтэй.

*ОҮИТБС нь дэлхийн улс орнууд байгалийн баялгийн салбарынхаа орлого, төлбөрийн тухай мэдээллийг системтэйгээр ил болгох, түгээх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн энгийн механизмыг санал болгодог.*

3. **Байгалийн баялаг ихтэй бүх улс орон ОҮИТБС–ыг хэрэгжүүлэх хэрэгтэй.** Ил тод байдал сул байх нь орлогын тодорхой түвшин, эсхүл бүс нутгаар хязгаарлагддаггүй болохыг тус индекс харуулж байна. ОҮИТБС нь дэлхийн улс орнууд байгалийн баялгийн салбарынхаа орлого, төлбөрийн тухай мэдээллийг системтэйгээр ил болгох, түгээх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн энгийн механизмыг санал болгодог. ОҮИТБС нь иргэний нийгмийн байгууллагуудтай мэдээлэл, олж мэдсэн зүйлээ хуваалцах тодорхой аргачлал, туршлагаас гадна олон янзын сонирхогч талуудын дунд итгэлцэл бий болгоход чиглэсэн олон улсын гэрээгээр хангадаг. Энэ санаачлагыг Норвеги гэх мэт хөгжингүй орнууд хэрэгжүүлж байна. Мөн ОҮИТБС-ын хэрэгжүүлэлтийг Ойрхи Дорнод, Хойд Америкийн бүс нутгийн байгалийн баялаг ихтэй баян орнуудаас гадна Австрали, Канад, Их Британи, АНУ зэрэг улсууд авч хэрэглэх ёстой.

